



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 26-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-27

1. “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	4-27
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
03 дугаар сарын 26-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 16 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ч.Анар, Н.Батсүмбэрэл, Н.Номтойбаяр, Д.Энхтүвшин;
Чөлөөтэй: Д.Энхтүвшин.

Нэг.Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, мөн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга Б.Хулан, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, мөн яамны Гэрээ, эрх зүйн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Соёлмаа, мөн газрын Хилийн хэлтсийн дарга Т.Баяржаргал, Зам, тээврийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Артур, мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Х.Итгэлт, мөн газрын шинжээч Г.Дөлгөөн, Төмөр замын тээврийн хэлтсийн дарга Д.Мөнхбат, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, мөн компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын захирал Э.Түвшинжаргал, Борлуулалт, маркетинг, тээврийн газрын дарга О.Цэрэндондог, Хууль, эрх зүйн газрын дарга Э.Уянга, Уул уурхай, технологийн газрын дарга Ч.Алтанбагана нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр, Ө.Шижир, Н.Наранбаатар, Х.Жангабыл, Д.Ганбат, С.Эрдэнэболд, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Мөнхжаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр, Н.Наранбаатар, Э.Болормаа, Х.Жангабыл, Д.Ганбат нар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 4
Бүгд: 20
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Б.Жаргалан нарыг дэмжсэнээр тооцож, 90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 24 минут үргэлжилж, 25 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 80.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 40 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 13 цаг 16 минут

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна. Та бүхэнд ирцийг танилцуулъя.

Наранцэцэгийн Алтаншагай гишүүн, Очирбатын Амгаланбаатар гишүүн, Батын Батбаатар гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Хажекберийн Жангабыл гишүүн, Батбаярын Жаргалан гишүүн, Нанзадын Наранбаатар гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүд хүрэлцэн ирснээр 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна аа.

Ингээд хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Нэг асуудал байгаа.

Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам нүүрсний худалдаа Таван толгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл байгаад байгаа. Засгийн газар 3 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах асуудал байгаа.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Тэгвэл хэлэлцэх асуудалдаа орцгооё. Ингээд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам нүүрсний худалдаа Тавантолгой нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон БНХАУ-ын Засгийн газрын хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг та бүхэнд юуны өмнө эхлээд танилцуулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас сайд Туваан, тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Жавхланбаатар, мөн тус яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Намчинсүрэн, тус яамны Хуулийн хэлтсийн дарга Ганбаатар, тус яамны Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга Хулан гэж оролцож байна.

Гадаад харилцааны яамнаас Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Мөнхтүшиг, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын

захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Соёлмаа, тус яамны Гэрээ, эрх зүйн газрын хилийн хэлтсийн дарга Баяржаргал.

Зам, тээврийн яамнаас Зам, тээврийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Артур, тус яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Итгэлт, мөн тус яамны Төмөр замын тээврийн хэлтсийн дарга Мөнхбат, мөн тус яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын шинжээч Дөлгөөн гэсэн бүрэлдэхүүнтэйгээр оролцож байгаа юм байна.

Эрдэнэс Тавантолгой компаниас Эрдэнэс Тавантолгой компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Мөнхжаргал гэж байна уу? Мөнхжаргал, тус компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын захирал Түвшинжаргал, тус компанийн Борлуулалт, маркетинг, тээврийн газрын дарга Цэрэндондог, тус компанийн Хууль, эрх зүйн газрын дарга Уянга, тус компанийн Уурхайн технологийн газрын дарга Алтанбагана гэсэн бүрэлдэхүүнтэй оролцож байна аа.

Ингээд 2 улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Цэвэгдоржийн Туваан сайд танилцуулна. Таныг микрофонд урьж байна 5 номер.

Ц.Туваан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 68 дугаар тогтоолоор Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээг баталсан.

Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах Хятадын талтай хэлэлцэн тохиролцох үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 28 дугаар захирамжаар байгуулсан. Түүнчлэн Ерөнхий сайдын 2024 оны 59 дүгээр захирамжаар уг ажлын хэсгийн ахлагчаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд миний биеийг, дэд ахлагчаар Зам, тээврийн сайд Дэлгэрсайханыг тус тус томилсон.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 12 сарын 27-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэж Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай 58 дугаар тогтоолыг баталсан. Мөн олон улсын гэрээний тухай хуулийн 9.1-д заасны дагуу 2025 оны 1 сарын 22-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээрийн төслийг хэлэлцүүлж холбогдох Улсын Их Хурлын Байнгын хороогоор зөвшилцөх шийдвэрийг гаргасан.

Олон улсын гэрээний тухай хуулийн 9.4-д заасны дагуу Засгийн газрын шийдвэрийг 2025 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор тус тус хэлэлцүүлэн дэмжиж хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгох шийдвэрийг гаргасан. Улсын Их Хурлын 58 дугаар тогтоолыг баримтлан Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр зам нүүрсний худалдаа Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол

Улсын Засгийн газар болон БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрт 2025 оны 2 дугаар сарын 14-ний өдөр БНХАУ-ын Харбин хотноо гарын үсэг зурсан. Монгол Хятадын талын ажлын хэсгийн хамтарсан хуралдаанаар талууд үндсэн 3 шатны баримт бичиг байгуулахаар тохиролцсон. Хятадын талаас дээрх гэрээнүүдийн төслийг тохиролцох асуудлыг хэлэлцэх саналыг тавьж байгаа бол Монголын талаас Засгийн газар хоорондын гэрээг байгуулснаар бусад гэрээг хэлэлцэх эрх зүйн орч чин бүрдэнэ гэж үзэж байгаагаар илэрхийлсэн. Хэлэлцээрийн хувьд Монголын талаас нэгд төмөр замын царигийн өөр өөрийн стандарт дүрэм журмыг мөрдөх, төмөр зам ашиглалтад орсны дараа гуравдагч талын ачааг тээвэрлэнэ гэж,

2.Төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг нэг зурагтай, нэг гүйцэтгэгчээр хийлгэнэ гэж,

3.Суурь үнийг хамгийн сүүлд баталгаажсан үнээр тогтооно гэж зарчмын саналыг Хятадын талд хүргүүлсэн. Хятадын талаас эхний санал буюу өөр өөрийн царигийн стандарт дүрэм журмыг баримтална гэдэг саналыг хүлээн авсан. Нүүрсний үнийг анхны үнийг урт хугацааны гэрээний хамгийн өрсөлдөхүйц үнээр тогтоох саналыг ирүүлсэн.

Хоёр дахь санал буюу барилга угсралтын ажлыг нэг гүйцэтгэгчээр хийлгэх асуудлыг Хятадын талд хүлээн аваагүй тул ойрын үед төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу барилгын ажлын гүйцэтгэгчийг Төрийн худалдан авах ажиллагааны газар дээр тендер зарлаж сонгон шалгаруулахаар ажиллаж байна аа.

Хил дамнасан төмөр замын өртгийг бууруулах зорилгоор Зам тээврийн сайдын 2025 оны 1 сарын 7-ны өдрийн А/01 дугаар тушаалын хүрээнд БНХАУ-ын төмөр замын барилга угсралтын төрийн өмчит томоохон 2 буюу тухайлбал, CRCC, CCRCC компанитай уулзалтуудыг зохион байгуулж тус бүтээн байгуулалтын ажлын өртөг барилга угсралтын хугацааг бууруулах чиглэлээр хэлэлцэж 270 сая ам.доллараас 220 сая ам.доллар болгон 50 сая ам.доллараар барилга угсралтын ажлыг 30 сар байсныг 22-оос 24 сар болгон тус тус бууруулсан байна аа.

Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулагдсанаар Монгол Хятадын бусад 3 боомтыг төмөр замаар холбох, Монгол Улсын нүүрсний олборлолт, экспортын хэмжээ нэмэгдэж, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилт эрчимжиж, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх боломж бүрдэнэ гэж үзэж байна аа.

Хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Туваан сайдад баярлалаа. Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хууль санаачлагчдаас асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Ганбат гишүүнээр тасалъя. Хосбаяр гишүүн асуулт асууна.

Г.Хосбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Ерөнхийдөө энэ хил холболт энэ цогц асуудал яригдаж байгаа асуудлыг дэмжиж байгаа. Тэр бүс нутагт бид нар бас ажлын хэсэг гээд очиж ажиллаж байсан. Тэгэхээр усны асуудал байдаг яг хил дээр. Тэгэхээр хил холболт энэ төмөр замаа холбосон ч гэсэндээ усны асуудал тэнд хүн амьдрах, тэнд үйл ажиллагаа явуулахад ус чухал учраас энэ усны суурь судалгаа ус ер нь ундны хэрэглээний цэвэр устай хэзээ болох вэ? Энэ асуудал дээр ер нь нэлээн онцгой анхаарал хандуулахгүй бол тэнд чинь цэвэр усны асуудал ер нь нэлээн тулгамдсан асуудал болсон байгаа. Энд хариулж өгөөч ээ.

Хоёрдугаарт нь авто тээвэр, төмөр замын тариф, нүүрс тээврийн тарифууд өөр байх шиг байна. Өчигдөр Сангийн сайд жишээлбэл төмөр замын тээврийн тарифыг 50 хувиар Ханги Мандал руу буурууллаа гэж байна. Ер нь одоо энэ хил холболт хийгдсэнээр энэ төмөр замын тариф, авто тээврийн тарифаасаа ер нь ямаршуу харьцаатай ямар байх юм бэ? Энэ боомт чинь өөрөө нэг 20-оос 30 сая тонныг л гаргах хүчин чадалтай байгууламж. Ийм холболт хийнэ гэж ойлгоод байгаа.

Тэгэхээр ер нь энэ нүүрс тээвэрт чинь 10 гаран мянган тээврийн хэрэгсэл байна. Өчнөөн Монголчууд хөрөнгө оруулалт хийчихсэн байна. Хэдэн 100 сая долларын нүүрс тээврийн автомашин аваад ингээд ажиллаж байгаа хувийн хэвшил хувь хүмүүс байна аа.

Тэгэхээр эд нарыг ер нь яаж тооцож яаж бас бодож байгаа юм бэ?

Хоёрдугаарт нь тэр Гашуунсухайтаас Цогтцэций хүртэлх одоо байгаа ашиглаж байгаа замын хажуугаар бас нэг олон жилийн өмнө нэг авто зам эхэлсэн. Нөгөө хүмүүсийн ярьдаг баян Базараа тавьж эхлээд мөнгөгүй болчихсон гээд. Тэгээд энэ замыг ер нь хэзээ дуусгах юм бэ? Энэ зам ашиглалтад орчихвол энэ уртын тээвэр энэ юм нь бас сайжрах юм байна лээ шүү дээ. Аваар осол багасна. Одоо ингээд зөндөө асуудлууд шийдэгдэх учраас энэ авто зам дээр бас ямар байр суурь бодол байгаа вэ? Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Туваан сайд 5 номер.

Ц.Туваан: Хосбаяр гишүүний асуултад хариулъя.

Тэгээд бас дэмжиж байгаад баярлалаа. Хосбаяр гишүүн бас ажлын хэсэгт орж, газар дээр нь бас явж бүх нөхцөл байдалтай нэлээн нарийвчлан танилцсан учраас бас тэнд яригдаж байсан тодорхой асуудлуудын талаар ярьж байна. Усны асуудал бол энэ дээр маш тийм хүндрэлтэй асуудал. Өөрөөр хэлбэл маш гүн гүнзгий ухаад гүн өрөм тавиад энэ дээр ус байдаггүй. Одоогийн байдлаар усаа зөөврийн байдлаар шийдвэрлэж байгаа. Мөн саяхан экспортыг нэмэгдүүлэх ажлын хэсэг энэ Гашуун сухайт боомт дээр ажиллах үеэр энэ асуудал яригдаж энэ боомтын захиргаа энэ тэртэй бас бид нар нэлээн ярилцсан. Ойрын үед энэ дээр бас төсөв хөрөнгө гаргаж энэ ард иргэдийн тэнд байгаа ажиллаж амьдарч байгаа хүмүүсийн тухайн боомтын усан хангамжийн асуудлыг ойрын хугацаанд цогц байдлаар шийднэ гэдэг ийм асуудлыг яриад энэ ажлын хэсэг дээрээ ажиллах хүрээндээ бас энэ асуудлаа шийдье гэсэн ийм шийдэлд хүрсэн гэдгийг хэлье.

Төмөр замын тээвэр бол мэдээж олон улсад ч тийм байдаг. Авто замын тээврээс нэг зүтгүүрээр олон угсраа вагоныг чирч явдаг гэдэг утгаараа өрсөлдөхүйц байдаг. Тэгэхээр мэдээж үнэ тарифын хувьд бол зайнаасаа шалтгаалж байгаа. Саяын тэр ажлын хэсэг явж ажиллаад Зам тээврийн сайдын гаргасан шийдвэр бол Тавантолгойн нүүрсний уурхайгаас Ханги Мандал хүртэлх 530км зам дээр тээвэрлэж байгаа нүүрсний үнийн дотор багцад нь ордог суурь бүтцийн буюу 42 мянган төгрөгийн зардал ордог зардлыг 50 хувь бууруулж 21 мянган төгрөг болгосон. Тэгэхээр энэ бол мэдээж нүүрс тээвэрт бол тодорхой хэмнэлтийг гаргаж байгаа. Мөн үүнээс гадна уурхайгаас вагон дээр очих тэгээд тэр хооронд бас нөгөө чингэлэгтэй нүүрсийг зөөж ачих, мөн вагон боомт дээр очоод терминал дээр буугаад хил гарах хүртэл ингээд нийтдээ 4 төрлийн зардал гарч байгаа.

Энэ дээр экспортыг нэмэгдүүлэх ажлын хэсэг дээр тодорхой үүргүүдийг өгөөд оролцогч талууд буюу энэ нүүрсний уурхай тээвэр хийж байгаа тэр терминал эзэмшиж байгаа компаниуд энэ тэрдээ бас энэ үнийн асуудлыг ярьж байгаа. Одоо бол ер нь бид нар дотооддоо нүүрсний үнэ унасан байгаа тохиолдолд зардлаа хэрхэн бууруулах вэ гэдэг тал дээр нэлээн төвлөрч ажиллаж байгаа гэдгийг энд хэлье. Ер нь бол төмөр зам, энэ төмөр зам ашиглалтад орсноор 30 сая тонн нүүрсийг экспортод төмөр замаар гаргах нөхцөл байдал үүснэ ээ. Дээд хүчин чадал дээрээ гэж үзэж байгаа. Тэгэхдээ ер нь бол бид нар цаашдаа өнөөдрийн гаргасан байгаа 2024 оны гүйцэтгэлээр хийсэн 80 сая тонноо 2030 оноос 160 сая тонн болгож өргөжүүлэх нэмэгдүүлэх ийм зорилттой явж байгаа.

Тэгэхээр энэ төмөр замын тээвэр ашиглалтад орсон ч гэсэн хажуугаар нь явах авто тээвэр, одоогийн энэ авто тээврийг гүйцэтгэж байгаа жолооч нар тээврийн ачаалал бол буурахгүй гэдэг хэвээрээ байна. Өсөлт байгаа учраас хэвээрээ байна гэсэн ийм хүлээлттэй байгаа учраас манай тээвэрчдийн асуудал бол энэ дээр бага хөндөгдөнө. Мөн энэ нэмж уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлээд эндээс 2030 оноос 20 сая тонн болгоод тээвэрлэж байгаа энэ тээвэр дээр манай Зам, тээврийн сайдын Хятадын талтай ярьсан юу бол тээвэр дээр Монголын жолооч нараар энэ тээврийг гүйцэтгүүлэх энэ асуудлыг бас ярьсан байгаа гэдгийг хэлье.

Тэр замууд бол нэлээн хэдэн зам байгаа. Энэ дээр тэр одоо концессын гэрээ авсан таны хэлсэн тэр Базараа гээд хүнтэй тэр нэрээр л тэнд нэрлэгдсэн юм байна лээ. Энэ зам хийгдэхгүй нэлээн удаж байгаа. Өнөөдрийн Засгийн газрын хуралдаан дээр хүртэл ажлын хэсгийн хүрээнд.

Г.Тэмүүлэн: Шижир гишүүн асуулт асууя.

Ө.Шижир: Ажлын хэсгийнхэнд амжилт хүсье.

Тэгээд 2024 оны 12 сарын 27-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас 58 дугаар тогтоол батлаад энэ тогтоолын хүрээнд ажлын хэсгийг Засгийн газрыг энэ гэрээг хэрэгжүүл гэдэг ийм чиглэл өгсөн. Тэгээд энэ чиглэлийн дагуу бас энэ ажлын хэсгийн энэ Улсын Их Хурлын тогтоол чинь өөрөө бас нэг 12 заалттай, 2 бүлэгтэй байгаа. Тэгээд тэр бүрээс ингээд тухайлан орж ирсэн гэрээг энэ Улсын Их Хурлын 58 дугаар тогтоолтой ингээд харьцуулсан дүгнэлт хийж үзэхэд 2 асуудал ерөөсөө огт дурдагдаагүй байна энэ гэрээн дээр. Эхнийх нь Улсын Их Хурлын 58 дугаар тогтоолын 3 дахь заалт буюу Монгол Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хүрээнд хамтын ажиллагааны хүрээнд Эрдэнэс Тавантолгой ХК хувьцаа эзэмшиж байгаа ашигт

малтмалын тусгай зөвшөөрлийг бусад этгээдэд шилжүүлэхгүй байх гэсэн тогтоолын 3 дахь заалт энэ гэрээнд огт дурдагдаагүй байна.

Дараагийнх нь 58 дугаар тогтоолын 5 дахь заалт болох нэг өнгө, нэг үгээр хэлэх юм бол нэг төрлийн нүүрсийг сорчилж олборлуулахгүй байх, 2009 онд 27 сая тонн, 2030 оноос хойш 20 сая тонноос бууруулахгүй байх, мөн Эрдэнэс Тавантолгой компанийн уурхайн олборлолтын төлөвлөгөөтэй нийлүүлэн олборлох гэсэн энэ заалт ерөөсөө яг энэ гэрээнд огт дурдагдаагүй байна л даа. Тэгээд энэ Улсын Их Хурлын тогтоолын 3 болон 5 дугаар заалт энэ гэрээнд дурдагдаагүй байгаа нь ямар учиртай вэ? Тэгээд бусад хэлбэрээр ингээд орсон байна уу гээд харахаар ороогүй байна лээ. Яг ингээд нэг бүрчлэн детальчилж уншсан. Мөн дараагийнх нь нөгөө 9 дүгээр заалт болох энэ юунд аливаа алдагдал хохирол болон төмөр замын хэл холболтод шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлыг ирээдүйд дахин нэхэмжлэхгүй гэсэн энэ 3 заалт бол яг энэ батлагдаж байгаа энэ 3 гэрээнд огт яг тухайлан суугаагүй байна лээ гэдгийг хэлэх гэсэн юм.

Энэ дээр 1 дүгээрт хариулт авах гэсэн юм.

Хоёрдугаарх нь мэдээж энэ хил холболтын төмөр зам энэ чинь өөрөө нэг талаасаа бүтээн байгуулалт өрнөнө. Үүний дагуу суурьшлын бүс үүснэ. Тэгээд суурьшлын бүс үүсэхээр тэр суурьшлын бүсийн төлөвлөлтийг хаанах хариуцаж байгаа вэ, ямар хэлбэрээр төсөөлж байгаа вэ? Яг одоо энэ ганц Гашуун сухайт шиг нэг хэдэн гэр бариад тэнд 20 мянган хүн амьдруулахаар ингээд дахиад өрнөх үү?

Тэгээд энэ 2 асуулт дээр тодорхой хариулт авах гэсэн юм. Эхнийх нь тэр Улсын Их Хурлын тогтоолын 3, 5, 9 дүгээр заалтууд энэ гэрээнд огт дурдагдаагүй буюу огт ороогүй байна. Ямар нэгэн байдлаар аль ч хэсэгт суугаагүй байна.

Бусад нь бол энэ гэрээнд суучихсан байна. Хоёрдугаарх нь тэр суурьшлын бүстэй холбоотой.

Г.Тэмүүлэн: Шижир гишүүний асуултад хариулъя. Туваан сайд.

Ц.Туваан: Шижир гишүүн бас энэ гэрээг маш нарийн уншиж танилцсан байна аа. Тэгэхээр Улсын Их Хурлын энэ гэрээ хэлэлцээр байгуулахад бид нар үндсэн чигээ батлуулж авсан. Энэ чигийнхээ хүрээнд ямар ч хазайлтгүй нэг ч зүйл заалт орхигдолгүй оруулсан гэдгийг хэлье. Засгийн газар хоорондын хэлэлцээр бол ер нь олон улс дээрээ ерөнхийдөө бас нууц, дээрээс нь бас детальный биш, ерөнхийдөө нэлээн томоохон асуудлуудаа авч оруулаад зарчмын хувьд авч оруулаад явдаг юм байна лээ. Үүнээс гадна бид нар түрүүн миний хэлсэн танилцуулга дотор 3 түвшний баримт бичгийг энэ дээр хийхээр заасан. Үүний хамгийн эхнийх нь Засгийн газар хоорондын хэлэлцээр.

Хоёр дахь нь ажлын хэсэг хоорондын протокол. Энэ протокол дээр мөн Харбин дээр гарын үсэг зурсан.

Гурав дахь асуудал нь бол энэ хэлэлцээр Улсын Их Хурлаас соёрхон батлагдмагц орох 3 ТӨК-удын хоорондын байгуулах гэрээ байгаа юм гэдгийг хэлье.

Тэгээд таны асуултад тодорхой хариулахад энэ 1 дүгээр асуултад нь энэ 4.3 дээр өөрөөр хэлбэл протоколын 4.3 дээр оруулсан энэ дээр болохоор Чайна

Энержи группийн зүгээс Тавантолгой ордын лиценз хувь эзэмших зэрэг саналыг тавихгүй гэдгээ илэрхийлж баталгаажуулсан гэж 4.3 дээрээ зааж өгсөн байгаа.

Хоёрдугаарт нь энэ сорчлон олборлохтой холбоотой асуудал дээр бол бид нар өмнө нь бас Үндсэн чиг батлуулах хүрээндээ ярьж байсан. Энэ ордоос 13 давхаргын нүүрс гарч ирнэ. Энэ дотор ерөнхийдөө манай биржээр арилжаалагддаг баяжуулснаас бусад 3 төрөл буюу коксжих 3-ны 1 нь коксжих эрчим хүчний гэсэн ийм 3 төрлийн нүүрс гарч ирнэ. Энэ 3 төрлийн нүүрсийг тухай бүрд нь үнэлж 55, 35, 10 гэсэн харьцаагаар борлуулахаар энэ харьцаагаа протоколын 5 дугаар дээр тохирч оруулсан гэдгийг бас танд хэлье.

Дараагийнхад нь бол энэ суурьшлын бүсийн асуудал мэдээж үүснэ. Энэ суурьшлын бүсийн асуудал дээр бол энэ боомтын захиргаа гэж ажиллаж байгаа. Тэгээд боомт хариуцсан хүн, дээрээс нь Монгол Улсын Засгийн газар дээр Боомтын сайдын харьяаны хүрээнд боомт хариуцсан дарга ажиллаж байгаа. Энэ хүрээндээ энэ асуудлууд шийдэгдэнэ ээ. Мөн одоо энэ алдагдалтай холбоотой асуудал дээр мөн 4-ийн 3 дээр протоколын 4-ийн 3 дээр оруулсан гэдгийг танд хэлье.

Тэгээд энэ дээр бол энэ нөгөө агуулга нь бол энэ төмөр замын өнгөрсөн хугацаанд бодитоор үүссэн алдагдал болон холбогдох боломжуудыг ирээдүйд нэхэмжлэхгүй гэдэг ийм зүйл заалтаар тусгаж оруулсан байгаа гэдгийг хэлье.

Г.Тэмүүлэн: Шижир гишүүн нэмж тодруулъя.

Ө.Шижир: Туваан сайдаа бид нарт протокол байхгүй болохоор тэрийг уншаагүй болохоор мэдэхгүй байна. Яг Их Хурлын гишүүдэд тараасан бид нар гэрээний хүрээнд л дүгнэлт харьцуулсан дүгнэлт хийж байгаа юм. Тэр протоколоо 1 дүгээрт Их Хурлын гишүүдэд өгөөч.

Хоёрдугаарх нь энэ 6.5.3 болон 6.1 дэх заалтууд нь жишээ нь аль нэг талд хэлэлцээрийг цуцлах тохиолдолд дипломат шугамаар гээд мэдэгдээд нөгөө талын зөвшөөрлийг авна гээд. Хэрвээ энэ тохиолдолд хэл холболтын хэлэлцээр цуцлагдлаа гэхэд түүнийг дагалдуулан байгуулсан гэрээнүүдэд үйлчлэлд л тийм зогсохгүй мэтийн бас тийм хууль эрх зүйн ойлголт бас нэг давхардаад байгаа юм. Тэгэхээр энэ тал дээр бас нэг та хэд маань ямар байр суурьтай байгаа юм? Мөн 5.3 дээр бас 2 улсын ААН хооронд өмнө байгуулсан нүүрс худалдах худалдан авах гэрээний биелэлт энэ гэрээнд нөлөөлөхгүй гэхихсэн. Тэгэхээр энэ нь өөрөө бас энэ Улсын Их Хурлын тогтоолд алдагдлыг тооцогдохгүй юман дээр хамрагдаж байгаа юу, хамрагдахгүй байгаа юу гэсэн ийм 2 нэмэлт тодруулга.

Г.Тэмүүлэн: Асуултад нэмж хариулъя. Туваан сайд.

Ц.Туваан: Мэдээж энэ гэрээ бол өнөөдрийн энэ Байнгын хороогоор бид нар асуудлаа оруулаад Улсын Их Хурлын чуулганаар соёрхон батлуулснаар Улсын Их Хурал, Засгийн газрын зүгээс хийх ажлууд өөрөөр хэлбэл эрх зүйн шийдвэрүүд ингээд дуусаж байгаа. Үүний дараагаар бол 2 төрийн өмчит ААН-үүдийн хоорондын гэрээнүүд, нөгөө 3 гэрээ, төмөр замын нэг, нүүрс худалдах худалдан авах нэг, нүүрсний уурхайн хүчин шатыг нэмэгдүүлэх гээд ингээд 3 гэрээ явна. Үүнээс гадна бас энэ Эрдэнэс Тавантолгой компанитай явуулж байгаа компаниудын урт хугацаатай гэрээнүүд байгаа. Энэ гэрээнүүдийн асуудалтай бол хамааралгүй гэж ингэж ойлгож болно.

Дээрээс нь энэ дээр ямар нэгэн гэрээн дээр ямар нэгэн маргаантай асуудал гарах юм бол зохицуулах заалтууд тодорхой тусаж өгсөн байгаа гэдгийг хэлье.

Г.Тэмүүлэн: Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Хэлэлцээрийг соёрхон батлахыг бол дэмжиж байгаа. 58 дугаар тогтоол дээр говиос ялангуяа сонгогдсон гишүүд санал гаргаад тэр 12 дахь заалт, 1.12-т нь орон нутгийн асуудал, байгаль орчны асуудал, ажлын байрны асуудал, усны асуудал, цөлжилт, шар шороо тоосжилтын асуудлыг оруулж өгөөрэй гээд бүр Их Хурлын 58 дугаар тогтоол дээр тусгайлан оруулж өгсөн шүү дээ. Энэ хэлэлцээр дээр бол алга байна. Тэгээд сая хариултаас сонсож байхад дахиад энэ хэлэлцээрийн соёрхон батлагдсаны дараагаар 3 гэрээ хийгдэх юм байна шүү дээ компани хоорондын.

Тэгэхээр энэ дээр ороогүй юм чинь цаашаага энэ гэрээнүүд дээр орох юм уу, үгүй юм уу? Орвол аль гэрээн дээр нь энэ цаашаага яаж тусгагдаж явах юм бэ? Энэ төсөл хэрэгжсэнээрээ уурхайн хүчин чадал нэмэгдэнэ олборлолт нэмэгдэнэ тэнд очиж ажиллах хүмүүс нэмэгдэнэ. Байгаль орчинд сөрөг нөлөөлөл буюу тэр тоосжилт усны хэрэглээ бүүр л их нэмэгдэнэ. Үүнийгээ дагаад тэр суурьшлын бүсийн асуудал, тэр сургууль цэцэрлэг төвлөрлөө дагаад хүрэлцээ хангамж, төрийн үйлчилгээ, эмнэлэг гээд олон асуудлууд ингээд цаашаа яригдаад эхэлнэ ээ.

Тэгээд энийгээ компаниас асуухад яаж төлөвлөж байгаа юм бэ? Энэ бол удахгүй, одоогоороо шийдлээ хүлээсэн ийм асуудлууд бий болчихоод байгаа. Энэ ажил эхлэхээр улам цаашаага өргөжөөд ингээд явах юм аа. Тэгээд одоогоороо Цогтцэций сум яг одоо энэ төсөл хэрэгжих уурхайн дэргэд байгаа Цогтцэций сумын хүмүүсийн эрүүл мэнд тоосжилтын асуудлыг та бүхэн надаар хэлүүлэлтгүй мэдэж байгаа. Эмнэлэг нь гэхэд подвал нь усанд автчихсан үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй. Сургуулийн дээвэр нь дотроосоо тааз нь нураад хүүхдийн толгой тархи гэмтээчихсэн. Уух ус нь одоо эрүүл мэндийн шаардлага хангахгүй.

Тэгээд л малчдын хувьд малаа бэлчээх газар нутаггүй болчихсон, цөлжилт бий болчихсон, худаг ус нь ширгэчихсэн ийм байгаа шүү дээ. Тэгээд энэ төсөл маань цаашаага өргөжөөд ингээд явахаар энэ асуудлуудаа яаж шийднэ гэж ингэж төлөвлөөд байгаа юм. Би одоо оны өмнө бас энэ асуудал орж ирж байхад хэлж л байсан. Энэ орон нутгийн асуудлыг оруулж өгөөрэй, тусгаж өгөөрэй компаниас энэ оныхоо төсвийг батлахдаа тэр сургуулийн асуудал дутуу баригдаад хаячихсан сургуулийг гүйцээх хөрөнгө төсвийг шийдэж өгөөрэй гээд бичгээр ч хүсэлт өгсөн амаараа ч өгсөн. Тэгээд ингээд нэгийг нь ч хүлээж авахгүй юм. Алтыг нь аваад авдрыг нь хаяна гэдэг шиг байгалийн баялгийг нь ашиглаж байгаа бол эргээд энэ байгаль орчинд нь тэнд амьдарч байгаа хүн зон орон нутгийн хөгжилд нь тус дэм болдог үр өгөөжтэй байх ёстой шүү дээ.

Энэ төсөл хэрэгжсэнээрээ ер нь орон нутагт нь ямар үр өгөөж байх юм бэ гэдэг дээ нэг тодорхой хариулт өгөөдхөөч дараа нь тодруулъя.

Г.Тэмүүлэн: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Туваан сайд. 5 номер.

Ц.Туваан: Тэгээд энэ тийм Наранбаатар гишүүн зөв ойлгосон байна. Ерөнхийдөө 3 бүлэг асуудал байгаа. Тэрэн дотор эхнийх нь бол та бүхэнд өнөөдөр нөгөө Монгол Улсын хуулийн дагуу Улсын Их Хурлаар соёрхон батлуулах Засгийн газар хоорондын хэлэлцээр. Энэний ар дээр бид нар нэг та бүхэн нөгөө яриад байдаг 60 удаа хэлэлцэж ажлын хэсэг 2 талын Засгийн газраас байгуулсан ажлын хэсэг хуралдаж байж хийсэн асуудлууд бид нар багцлаад яг шийдвэрлэх асуудлуудаа протокол болгоод албан ёсны бичиг баримт болгоод дагалдуулаад гарын үсэг зурсан. Улсын Их Хурлын 58 дугаар тогтоол дээр орсон 12 зүйл заалтаас Засгийн газар хоорондын хэлэлцээрт оруулж болох заалтуудаа оруулаад бусад бүх заалтуудыг протоколдоо ямар нэгэн байдлаар оруулж орхилгүй тусгаж гарын үсэг зурж албажуулсан. Энэ дотор ерөөсөө ороогүй таны үгэнд дурдагдсан нэг л асуудал байгаа. Энэ шар шороон шуургатай холбоотой асуудал бол одоо бас яг энэ дээр тусаж чадаагүй. Яг энэ хоорондын энэ удаагийн арга хэмжээн дээр орж чадаагүй гэдгийг хэлье. Мэдээж энэ протокол дотор бол 5 дугаар зүйл, заалт дээрээ орон нутагтай холбоотой асуудлыг бид нар орон нутгийн байгаль орчны хамгааллын асуудал ESG стандарт мөн тухайн орон нутгаас ажиллах хүч авах асуудлыг анхаарч баримт бичигтээ тусгасан байгаа. Мөн энд ажиллах суурьшлын бүс байгуулж, энд ажиллах Монгол, Хятад ажилчдын байрлах байрнаас гадна сайн нөхцөлтэй дагалдах сургууль, эмнэлэг, цэнгэлдэх хүрээлэн зэрэг дэд бүтцийг байгуулах асуудлыг Монголын талын саналаар тусгасан гэдгийг бас энд хэлье.

Өнөөдөр бол Цогтцэций сумын нөхцөл байдлыг бид нар үнэхээр мэдэж байгаа. Яг тантай тэр алтыг нь аваад авдрыг нь хаяна гэдэг үгтэй тохирохуйц нөхцөл байдал бол байгаа. Тэгэхээр бид нар энийг анхаарах тал дээр Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдаад таны ахалж байгаа Ашигт малтмалын тухай хуулийн ажлын хэсэг дээрээ ерөөсөө л гишүүдээс гарч байгаа гол концепц буюу энэ орон нутагт нь алтыг нь авсан юм бол авдарт нь юмыг нь өгөх буюу тэр АМНАТ-ын тодорхой хувийг тухайн уул уурхай ашиглаж байгаа сум, аймгийн төсөвт нь, орон нутгийн санд нь үлдээх гэдэг энэ зарчим шийдэгдчихвэл энэ асуудал бас нэлээн нааштайгаар шийдэгдэнэ.

Дээрээс нь тэнд ажиллаж амьдарч байгаа орон нутгийн ард иргэдийн асуудал бол нэлээн сайн шийдэгдэнэ гэж ингэж үзэж байгаа. Мөн одоо нөгөө талдаа Гашуунсухайт-Ганцмод боомт дээр сая ажлын хэсэг ажиллаад тэнд байгуулах эмнэлгийн асуудлыг бол зураг төслийнх нь асуудал шийдэгдсэн. Ирэх жилийн төсөвт тусгахаар онцгой байдлын анги байгуулах асуудлыг нь газар дээр нь ингээд шийдээд ирсэн байгаа гэдгийг танд хэлье ээ.

Г.Тэмүүлэн: Наранбаатар гишүүн нэмж тодруулъя.

Н.Наранбаатар: Эрдэнэс Тавантолгой компанийн удирдлагуудаас асууя. Орон нутагтай харилцах чиглэлээр танай дээр ямар салбар нэгж компанийн бүтцэд байгаа юм. Тэгээд энэ жил юу хийхээр төлөвлөсөн юм, орон нутгийн харилцаа ер нь ямар байгаа юм гэдэг дээр тодруулж өгөөч ээ. Байхгүй бол цаашдаа энэ орон нутагтай харилцах тусдаа газар хэлтэс байгуулж тэр орон нутагт хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр шинэ суурьшлын бүсийн асуудлыг бүр тусад нь авч үзэхгүй бол болохгүй болсон.

Дараагийн асуудал энэ Гашуунсухайтын боомтыг олон улсын зэрэглэлтэй болгох асуудал ер нь яригдсан юм уу? Ямар хэмжээнд яригдсан юм? Ганцхан байгалийн баялаг гадагшаагаа төмөр замаар урсаад байх боомт байх юм уу. Эргээд

хоосон орж ирж байгаа машин, төмөр зам, вагон дээрээ бас нөгөө олон улсын боомт болоод бараа бүтээгдэхүүн барилгын материал бусад юмнууд орж ирдэг ийм боомт болох юм уу? Аль эсвэл ингээд 2 улсын статустай боомт байгаад байх юм уу? Ер нь боомтын хөгжлийг цаашаа яаж төлөвлөж байгаа юм?

Г.Тэмүүлэн: Наранбаатар гишүүний асуултад хариулъя 7 номер.

Х.Мөнхжаргал: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Эрдэнэс Тавантолгой ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Мөнхжаргал байна аа. Компанийн хувьд болохоор орон нутгийн удирдлага болон холбогдох нэгжүүдтэй нь бол хамтын ажиллагааны гэрээ байгуулсан 2 талаасаа бүрдсэн ажлын хэсгийн байдлаар асуудлаа шийдээд хэлэлцээд хурлаа хийгээд явж байгаа. Орон нутгийн хөгжлийн сангийн тухай хуулиараа жил болгон гэрээнийхээ хүрээнд бол бид нар 3-аас 5 тэрбум төгрөгийг орон нутгийн хөгжилд зориулаад шилжүүлээд ажиллаж байгаа санд төвлөрүүлээд. Энд 2025 оны хувьд бол хамтын хорооны хурлаараа ямар ажил хэрхэн хийх талаараа хурлаараа шийдээд манай компани руу ирүүлье гэсэн тийм хувилбартай байгаа. Энэ жилийн хувьд бол 5 тэрбум төгрөгийг бол.

Г.Тэмүүлэн: эмээд хариулъя 7 номер.

Х.Мөнхжаргал: Түрүүн бас нөгөө олон улсын хэлэлцээр болон протокол дээр бас орсон ороогүй асуудлаар бас тэгээд тэрэн дээр нэмэлт бас мэдээлэл өгөхөд сэргээгдэх эрчим хүч нөгөө говийг усжуулах шар шороон шуурга, цөлжилттэй тэмцэх, мөн орон сууцжуулалтын асуудал, сургууль, эмнэлэг, цэцэрлэг зэрэг хувилбарт шийдэл бүхий нөхцөлөөр хамтран ажиллахаар одоо нөгөө уулын ажлыг хүчин чадлыг нэмэгдүүлэх ерөнхий гэрээн дээрээ компанийн зүгээс төсөл дээр нь тусгаад нөгөө орхигдсон заалтуудыг нь бүгдийг нь нэмээд оруулчихсан байгаа гэдгийг хэлэх гэсэн юм. Гэрээн дээрээ гэсэн үг.

Г.Тэмүүлэн: Боомтын асуудлаар 3 номер. Мөнхтүшиг дарга 3 номер.

Л.Мөнхтүшиг: Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Мөнхтүшиг байна аа. Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Гашуунсухайт-Ганцмод боомтын статустай холбоотой асуудлаар сүүлийн 10 гаруй жил ГХЯ дипломат шугамаар Хятадын талтай ярьж хүсэлт тавьж ирсэн. Тэгээд яг боомтын асуудлыг бол 2 улсын хилийн боомтыг зохицуулдаг 2004 оны хэлэлцээрээр шийдвэрлэдэг. Тэгэхээр Хятадын тал бол 2 талын гэдгээр нь бол хадгалах байр сууриа бол тууштай илэрхийлээд явж байгаа. Гэхдээ бид гуравдагч орны иргэдийг оны эхэнд 2 тал дипломат шугамаар ингээд солилцоод гуравдагч улсын иргэдийг нэвтрүүлэх зохицуулалтуудыг хийгээд сүүлийн жилүүдэд явж байгаа. Төмөр замын боомт болгох асуудлыг сая сүүлд 2020 онд БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Монгол Улсад айлчлахад 4 боомтыг хилийн төмөр замаар холбохоор шийдвэрлэсний нэг нь ингээд Гашуунсухайт-Ганцмод болоод явж байна аа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Жангабыл гишүүн асуулт асууя.

Х.Жангабыл: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Энэ хэлэлцэж байгаа хэлэлцээрийг бол дэмжиж байна. Надад нэг хэд хэдэн асуулт байна. Бид бүтээн байгуулалтын ажлыг яаралтай эхлэх хэрэгтэй байна. Дээрээс нь 5 сая тонн нүүрсээ бас худалдаалах хэрэгтэй байна. Тэгэхээр 1 дүгээрт энэ гэрээний энэ хэлэлцээрийг хэзээнээс дагаж мөрдөх юм бэ? Хугацаа нэг дэх асуулт.

Энэ хэлэлцээрийг дагаж ямар нэг хууль тогтоолд өөрчлөлт орох юм уу? Жишээлэхэд энэ үнэний асуудал. Одоо хүчинтэй байгаа Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 10.4-д заасны дагуу гэрээ хэлэлцээрийг батлахдаа тухайн бүтээгдэхүүний биржийн арилжааны дундаж үнийг баримтлан гэж заасан байдаг юм. Гэхдээ энэ хэлэлцээрийг би нарийн судалсан л даа.

3.2-т бол баахан юм биччихсэн сүүлд баталгаажсан үнэлгээ хийнэ анхны үнэлгээ хийнэ баахан индекс учрыг нь олохоо болилоо бүр. Энэ дээр ямар ямар индексүүд байдаг юм бэ? Индексээр ингээд тохируул гаргана л гэнэ. Энийг бол тайлбарлаж өгөхийг хүсэж байна аа. Ер нь л ямар нэг хэлэлцээрийг хийхдээ үнэ, чанар, хугацаа шүү дээ. Тэгэхээр энэ бол энэ бидний зарах гэж байгаа бүтээгдэхүүний нүүрсний үнийг болбол гэрээн дээр энэ хэлэлцээр дээр тодорхой бид тусгаж өгөхгүй бол дараа нь маргаан гарах вий гэсэн үүднээс.

3 дахь асуулт. 2.2-т Монголын талаас хамаарал бүхий хуулийн этгээдүүд гэж бичсэн байна. Тэгээд Монголын талаас ямар ямар компаниуд энд оролцох юм бэ? Тодорхой хэлж өгмөөр байна. Хятад талаас ч гэсэн тийм утга бүхий өгүүлбэр орсон байна. Хятадын ямар ямар компаниуд энд оролцох юм бэ?

4 дэх асуулт.

6 дугаар нэмэлт заалт дээр хэлэлцээр 16 жилийн хугацаанд хүчинтэй. Энэ гэрээг цуцлахаар бол нөгөө талын зөвшөөрлөөр гээд заачихсан. Нөгөө тал нь зөвшөөрөл өгөхгүй бол гэрээг цуцлахгүй юм уу? Иймэрхүү л асуултууд байна даа.

Г.Тэмүүлэн: Жангабыл гишүүний асуултад хариулъя. 5 номер Туваан сайд.

Ц.Туваан: Жангабыл гишүүний асуултад хариулъя аа. Дэмжиж байгаад баярлалаа.

Энэ дээр 3 гэрээний эхнийх нь үгүй ээ 2 дахь нь буюу нүүрс худалдах худалдан авах гэрээн дээр 25, 26, 27 онд тус бүр тав таван сая, 28, 29 онд зургаа зургаан сая. Энэ 5 жилийн нүүрс нийлээд 27 сая тонн. Үүнээс хойш 6 дахь жилээс эхлээд жил болгон 20 сая тонн гээд ингээд нүүрс худалдан авах хэмжээгээ тодорхой болгочихсон. Тэгээд бас та бүхний дэмжлэгтэйгээр батлагдсан энэ Байнгын хорооны дэмжсэн шийдвэр энэ Засгийн газрын хэлэлцээр бол бас яг цагаа олж байгаа. Яагаад гэхээр сүүлийн үед дэлхий дээр энэ Трамп тариф гарч ирээд энэ гангийн урд хөршийн гангийн экспортын асуудал энэ тэртэй холбогдуулаад нүүрсний үнэ унаж байгаа. Тэгээд энд яригдаж байгаа 5 сая тонн нүүрсний нүүрсийг бас яаралтай зармаар байна гэдэг нь зөв. Энэ шууд гэрээндээ 2 компани хоорондоо гэрээгээ байгуулж эхлээд л өнөөдрийн Эрдэнэс Тавантолгой компанийн олборлож байгаа хүчин чадал дээр дотоод нөөцөө ашиглаж нэмэлт 5 сая тонныг бэлэн мөнгөөр борлуулах асуудал байгаа юм.

Энэ бол ойролцоогоор нэг 400 орчим сая доллароос дээш хэмжээний борлуулалтын орлого бас ороод ирэх ийм нөхцөл бүрдэж байна гэж ингэж ойлгож болно. Хууль тогтоомжид бол ямар нэгэн өөрчлөлт бол яг энэ энэ хэлэлцээртэй холбогдож орохгүй. Энэ өөрөө олон улсын гэрээ эрх зүйн хүрээнд Засгийн газар хоорондын хэлэлцээр байгаа учраас энэ Уул уурхайн биржийн тухай хуулийн энэ зүйл заалтад хамрагдахгүй явна гэдгийг бас хэлье. Үүн дээр бол мэдээж бид нар

бас нэлээн олон удаа ярьсан. Энэ дээр бол олон улсад баримталдаг буюу нүүрсний борлуулалтыг урт хугацаанд тогтвортой ийм гэрээнүүдээр борлуулалтыг хийдэг. Манайд бол Уул уурхайн биржийн тухай хуулиар арилжаад явдаг. Тэгэхээр энэ удаагийн Засгийн газар хоорондын хэлэлцээр дээр бол энэ урт хугацаандаа хийгдэж байгаа гэрээ учраас бас тодорхой буюу өнөөдрийн Эрдэнэс Тавантолгойн компаниас нүүрс худалдан авч байгаа 4 компанийн үнэ бол тодорхой ийм тогтвортой үнээр тогтвортой юу байх вэ ер нь бол гэрээний үнээр явж байгаа.

Тэгээд энэ үнэ бол Хятадын дотоод зах зээлд хилийн боомтууд дээр зарагдаж байгаа 5 индексийн үнэ дээр нэмэх нь суурь үнэ ороод ингээд энэ үнүүдийн дунджаас энэ үнэ бүрдэнэ. Улиралдаа нэг удаа энэ үнэ дээр хөдөлгөөн орохоор ийм үнээр явж байгаа гэдгийг хэлье.

Мөн одоо энэ компаниудын тэгээд энэ бол үнэ чанар хугацаатай холбоотой асуудлууд бол яг энэ нүүрс худалдах худалдан авах 2 улс компанийн хоорондын гэрээн дээр чанарын асуудал болоод хэмжээний асуудал, үнийн асуудал дээрээс нь тэр нөгөө лабораторийн шалгах асуудал мөн энэ янз бүрийн маргаан гарвал гэсэн асуудлууд тодорхой заагдаад явж байгаа. Тэгэхээр энэ 2 улсын хооронд байгуулж байгаа энэ Засгийн газрын хэлэлцээрийг Их Хурлаар соёрхон батлагдмагц бид нар дараагийн гэрээ рүү ороод явна аа.

Тэгэхдээ тэр гэрээнүүдийн драфтууд ерөнхийдөө бэлэн болчихсон байгаа гэдгийг хэлье ээ. Монголын талаас бол энэ дээр нүүрс худалдах, худалдан авах гэрээ, уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх дээр Эрдэнэс Монгол компанийн харьяа Эрдэнэс Тавантолгой компани оролцоно. Хятадын талаас бол Чайна Энержи төрийн өмчит компани оролцоно. Төмөр зам дээр бол тендер зарлаад ингээд орно. Монголын талаас Тавантолгой төмөр зам компаниуд оролцоод явна гэдгийг хэлье ээ.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн асуулт асууя.

Д.Ганбат: Энэ гэрээ их чухал. Тэгээд тэр тусмаа Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор орж байгаа нь зүйтэй л байна л даа. Монгол Улсын аюулгүй байдалтай нэлээн холбоотой гэж би бодож байна. Ер нь бол 100 сонсохоор нэг удаа хараа гэгчээр энэ бүх юмыг очиж харсан. Заримд нь зарим гишүүдтэй хувийн зардлаар хүртэл явж юмыг зарим зүйлийг нь харлаа. Зарим нь энэ Аж үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан, Эрдэс баялгийн яамнаас зохион байгуулсан энэ үзэх харах юманд нь оролцсон. Бас нэлээн мэдээлэлтэй нэлээн ойлголттой болсон. Энэ хил холболт гэж яриад байгаа. Энэ гэрээ бол хил дамнасан төмөр зам гээд байж л байна л даа. Энэ хил холбож байгаа юм уу хил дамнаж байгаа юм уу? Яг юу гэж ойлгох юм энийг тиймээ. Тэгээд ярихаараа болохоор цаашаа PR-аа хийхээр болохоороо хил холболтын төмөр зам гэж яриад байдаг. Энэ гэрээн дээр болохоор хил дамнасан төмөр зам гээд байдаг. Энийгээ нэг мөр болго. Тэгээд та бүхний PR бол одоо нэг бараг асуугаад тодорхой болгоод 7 хэмжиж байж нэг огтлох ёстой л доо. Уул нь бол энэ төмөр замыг аль хэдийнээ байгуулаад холбоод ингээд 10 жилийн өмнө л хийчих ёстой ийм л юм байсан.

2014 онд тэр цаанаасаа хил дээр төмөр зам ирчихсэн байна лээ ирчихсэн байсан гээд сууж байна лээ. Тэгээд ярьж байгаа нь болохоор Хятад улс ч бай аливаа нэг улс орон тэр өөрийнх нь ард түмнийх нь л хөрөнгө л байгаа шүү дээ. Компани ч бай тэр Улаан загалмай ч юм уу, халамжийн байгууллага биш. Өчнөөн

их алдагдалд орчихсон байгаа. Тэрийгээ зүгээр байхгүй болгоод ингээд явна гэсэн юм байхгүй. Үнэгүй юм оготнын хавханд л байгаа. Бид нар тэгээд 2 ордоо өгөх гэж байгаа юм шиг байна. Энэ 2 ордоо яалаа гэж өгч байгаа юм? Ямар учиртай юм? Тэгээд энэ гэрээн дээр чинь бас байна л даа. 3-ыг цогцоор нь гээд байгаа байхгүй юу? Тэр 3 гэрээ нь яг ямар учиртай ямар гэрээ юм. Юу юу байх юм? Энэ 3 гэрээ цогцоороо л байхгүй бол энэ гэрээ цаашаа явахгүй гэсэн ийм маягтай юмнууд бас байна.

Одоо бол хүмүүстэй уулзаад гадна дотнын тэр шинжээчтэй, аналистуудтай ярьж байхад бол тэгж л байна лээ шүү дээ. Монголын нүүрс ерөөсөө хил гараад л, нэг хоёр зуухан, гурван зуухан километр дотор л борлогддог. Тэр хавьд л нэг өрсөлдөх чадвартай. Цаашаа бол ямар ч өрсөлдөх чадваргүй гэж байгаа байхгүй юу. Уул нь тэр Чайна инержи бол ер нь төмөр зам бол Хятадын нутаг дэвсгэрээр хамгийн эхний ээлжид тэр Тяньжин, Дайлин гээд энэ юманд хүрчих боломжтой төмөр замын сүлжээтэй юм билээ. Тэр байтугай 2014 онд Си Жиньпин дарга ирээд манай Улсын Их Хуралд хэлж байхдаа та нар одоо бид нарын хөгжлийн хурдан галт тэргэнд суугаад ингээд хөгжиж болно. Гуравдагч зах зээлд нүүрсээ гаргаж болно оо гэхчхэн байсан. Одоогоор бид нар гаргаж чадахгүй болчхож байгаа юм байна цаашдаа. Зүгээр л мухар зам хил гараад л мухар зам. Зөрүүлээд нарийн төмөр зам орж ирнэ. Тэрний төлөөс нь бид нар ямар ч юм өгөөд байгаа юм, юу ч өгөөд байгаа юм. Тэгээд цаашдаа бол энэ нүүрс өрсөлдөх чадвар тийм сайн биш байх нь ээ.

Ер нь 200, 300 км-ээсээ цааш өрсөлдөж чадахгүй нь ээ. Уул уурхайн бүтээгдэхүүн гаргадаг манай хойд хөрш яг ижил адил төстэй. Тэднийх гэхэд сүүлийн 10 жилд 100 сая тэрбум тонн нүүрс гаргадаг болчихсон байгаа байхгүй юу. Тэгэхэд манайх ямар байна? Ийм л байгаа байхгүй юу. Тэгээд энэний төлөө ажиллаад байна. Яах гэж юу хийгээд байна? Энэ юмыг асууж байгаа тодруулж байгаа хүмүүсийг сайхан хариултыг нь өгмөөр байгаа. Гэтэл бүгдийг нь л дуугүй болгоод байх юм. Намайг бол чадахгүй л дээ. Би бол ямар янз бүрийн юманд холбогдсон энээ тэрээ юм байхгүй. Улсын Их Хурлын сонгогдоход өчнөөн олон компани надад дэмжиж хандив өгдөг. Тэрнээс нэг ганц, хоёр.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүний асуултад хариулъя. Туваан сайд 5 номер.

Ц.Туваан: Төмөр замтай холбоотой асуудал дээр Дэлгэрсайхан сайд ажлын хэсгийн дэд ахлагч нэмээд хариулчих нь зөв байх. Энэ сая энэ Засгийн газар хоорондын хэлэлцээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороогоор орж байх үед гишүүд тодорхой саналуудыг гаргасан. Тодорхой саналуудыг гаргахдаа гишүүд энэ гэрээг амжилттай болоосой, алдаа оноо байвал засаж залруулаасай гээд саналуудыг хэлсэн. Энэ санал дээр бид нар ажиллаад 2 тал дахиж хугацаа гаргаж ажиллаад бүгдийг нь бас аль болохоор нь тусгаад явсан. Тодорхой хэлэх юм бол энэ сэргээгдэх эрчим хүчний хамтын ажиллагааны асуудал.

Дээрээс нь бас нөгөө талын компани давуу эрхтэйгээр оролцох байдлыг харилцан ашигтайгаар. Дээрээс нь энэ нөгөө энэ эрчим хүчний нүүрстэй холбоотой гээд энэ асуудлуудыг бүгдийг нь бас засаж залруулаад эцсийн байдлаар хэлэлцээрт зурахдаа оруулаад явсан. Нэлээн сайжруулж оруулсан. Тэгээд энэ дээр бас манай Байнгын хорооны гишүүд бас үнэтэй санал хэлсэн байна лээ. Энийг бас тусгасан. Дараа нь би бас санал хэлсэн гишүүдэд бүгдээрэнг нь бас хэлсэн. Төмөр зам бол өөрөө ер нь бол олон улсын төмөр замын хэлэлцээрээрээ бол мэдээж хил

дамнасан төмөр зам хилийн зурвасыг давж гарч байгаа ийм төмөр зам. Бас нөгөө талаараа ч гэсэн энэ хоорондоо төмөр замаар холбогдож байгаа ийм асуудал байгаа.

Тэгэхээр энэ дээр Дэлгэрсайхан сайд бас нэмээд хариулчихна биз.

Энэ хэлэлцээрийн 1.1 дээрээ 3-ыг цогцоор гээд энэ 2 улсын хил дамнасан төмөр замын холболтын асуудал.

Хоёрдугаарх нь нүүрс худалдах худалдан авах гэрээний асуудал.

Гуравдугаарх нь бол уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх гэдэг асуудал байгаа. Тэгэхээр энэ 3 бол таны яг ойлголт зөв байна. Яг 3 гэрээ хамтаараа цуг хийгдээд ингээд цогц байдлаараа цаашаа явна гэдгийг хэлье ээ.

Г.Тэмүүлэн: Сая 2, 3 тодорхой асуултууд л асуусан даа Туваан сайд аа. Саяын тэр орд ашиглах эрхтэй холбоотой асуудал, нүүрсний өрсөлдөх чадвартай холбоотой асуудлууд гээд тэрэн дээр та хариулах уу? 5 номер.

Ц.Туваан: Өнөөдрийн Эрдэнэс Тавантолгой компани маань бол одоо хамгийн боломжит дээд хүчин чадлаараа жилийн 30 сая тонн нүүрсийг өөрийн уурхайгаасаа олборлож экспортод гаргаж байгаа. Мөн энэ удаагийн төмөр замын хэл холболт явагдтал энэ хугацаанд ба бас дотоод нөөц бололцоогоо дайчилж нэмж энэ шинээр борлуулах худалдах 5 сая тонныг олборлож бэлэн мөнгөөр борлуулна гэж ингэж ойлгож болно. Энэ төмөр зам маань өөрөө бид нар бүгдээрээ бас явахдаа үзсэн. Төмөр зам маань бол одоо Хятадын дотоодын олон улсын төмөр замтай холбогдоод цаашаа яваад далайн Тяньжин, Тяньжиний дээд талаар гээд 2 боомттой шууд ийм холбогдох төмөр зам байгаа. Тэгээд энэ төмөр замаар бас Тяньжинээс энэ өөрөө төмөр замын холболт орсноор Тяньжинийн буюу тэр боомтоос ачаа тээвэр энэ боомт дээр төмөр замаар ирэх боломжийг бас давхар бий болгоно.

Дээрээс нь энэ ганцхан энэ Чайна Энержи компанийн нүүрсийг тээвэрлэхгүй гэдэг зүйл заалтыг бол гэрээ хэлэлцээрт оруулж өгсөн байгаа. Мөн энэ төмөр замаар Хятадын талаас бас нефтийн бүтээгдэхүүн оруулж ирэхээр байгаа. Энэ компани өөрөө жилдээ 1 800 сая тонноос 1 тэрбум тонн нүүрс худалдаж авч эрчим хүчний зориулалтаар эрчим хүч үйлдвэрлэх зориулалтаар ашигладаг ийм компани. Монголын талаас орж ирж байгаа нүүрс бол хилээс 500 орчим километрийн радиус дотор өрсөлдөх чадвартай гэдэг ийм танилцуулгыг бас бид нарт хийсэн гэдгийг нэмж хэлье.

2 ордыг бид нар өмнө нь тэр ярьж байсан. Түрүүн би бас дурдсан. Энэ лицензтэй холбоотой хувь эзэмшилтэй холбоотой ямар ч асуудал байхгүй. Энэ дээр бид нар нөгөө нүүрсний олборлолтоо ганцхан энэ компанид ч биш ер нь цаашдаа 160 сая тонн хүргэхийн тулд бид нарт тэртээ тэргүй уурхайн хүчин чадлаа нэмэгдүүлэх шаардлага байгаа. Энэ дээр оператор компанийг шалгаруулаад эндээс олборлолтоо нэмэгдүүлэх ийм байгаа гэдгийг хэлье.

Г.Тэмүүлэн: Дэлгэрсайхан сайд нэмж хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Ганбат гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт бол таны хэлж байгаатай бас санал нэг байна. Яагаад вэ гэхлээр төмөр зам өөрөө 2 талаасаа 2 өөр цариг байгаа. Тийм учраас 2 улс анх энэ гэрээг байгуулахдаа 2 талын бие биеийнхээ царигийг харилцан хүндэтгэж аль алиныхаа хилийн зурвас руу оруулна гэдэг дээр энэ гэрээний анхны концептод тусгагдсан байгаа, 1 дүгээрт.

Хоёрдугаарт манай уурхайгаас ачигдаад гарсан өргөн царигаар явж байгаа нүүрс бол цаад талдаа Ганцмодны Чайна Энержигийн өөрийнх нь ачиж буулгах терминал дээр буугаад тэр буулгалт дээр маш том буулгалтын терминал байгаа. Та өөрөө ингээд тухайн үед бид хамт явж байсан шиг санаж байна үзсэн. Тэрэн дээр нэг цуваа ороод 10-аас 15 минутын хооронд вагонтой нь хөмрөх маягаар тэгээд буулгаад тэгээд нарийн царигийн вагонд ачигдаад цаашаа одоо явах ийм боломжтой гэж. Тэгэхээр зэрэг 1 дүгээрт энэ бид өргөн царигаараа уурхай дээрээс нүүрс ачихад бол хамгийн багадаа 20 саяас доошгүй дээд тал нь 30 сая тонн хүртэлх ачих ийм боломж бололцоотой болж байгаа.

Хоёрдугаарт бол манай хил рүү нарийн царигийн төмөр зам нь орж ирж байгаа. Бид нарийн цэргийн төмөр зам дээр мөн ялгаагүй одоо нүүрсний тэр ачих, ачилтын терминал барина. Энэ барилгын ажлыг бол Тавантолгой төмөр зам өөрсдөө бид хийнэ. Тэгэхлээр энэ явцад бол бид нар энэ нарийн төмөр зам дээрээсээ машинаар тээвэрлэгдэж ирсэн нүүрсийг ачаад ингээд гаргахад энэ нүүрс маань цаашаа буухгүйгээр цаашаа нутгийн гүн рүү явах ийм боломж бололцоотой. Өөрөөр хэлбэл сая Туваан сайдын хэлдгээр Тяньжин боомт, энэ дотоодын төмөр замын сүлжээ.

Г.Тэмүүлэн: Нэмж хариулъя Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: Цаашаа нөгөө өөрийнхөө дотоодын төмөр замын сүлжээнд холбогдсон учраас энэ нүүрс бол аль ч газар хүрэх ийм бүрэн боломжтой гэдгийг хэлье.

Дараагийн дугаарт бол Чайна Энержи компани өөрөө эрчим хүчний компани. Түрүүн Туваан сайдад хэлж байсан. Энэ компанийн өөрийнх нь хэрэглээ бол жилд 800-аас 1 тэрбум тонн нүүрс хэрэглэдэг. Нийтдээ дэлхийн 8 орноос импортоор нүүрс авахаас гадна дотоодын нүүрсээ худалдаж авдаг. Тэгээд бид аль болохоор ийм том хэрэглэгчидтэй холбогдож илүү их нүүрсийг экспортлох ийм боломж бололцоо бүрдэж байгаа гэдгийг хэлье. Тэгээд энэ саяын хил дамнасан гэдэг төмөр замын байгууламж бол өөрөө нөгөө 2 улсын хилийг дамнаж хийгдэж байгаа гүүрэн байгууламж учраас нэр нь тэгж нэрлэгдэж байгаа юм аа.

Хил холболт гэдэг асуудал байхгүй. Хил холболт гэдэг бол угаасаа 2 улс хилээрээ ингээд холбоотой байгаа юм чинь. Тэрэн дээр ингээд үгний юу байгаа байх аа андуурч эндүүрч хэрэглээд байгаа гэж би ойлгож байгаа юм. Тэрнээс биш хил дамнасан төмөр замын байгууламж. Яагаад вэ гэхлээр энэ чинь нөгөө 1 талаасаа нарийн төмөр зам гүүрэн байгууламжаар 10 метр дээгүүр орж ирж байна, өргөн цэргийн төмөр зам нь өөрөө мөн гүүрэн байгууламжаар 30 метрийн өндөр дээгүүр гарч ирж байгаа ийм байгууламж учраас энийг тэгж нэрлэгдэж байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн нэмж тодруулъя.

Д.Ганбат: 2 сайдад баярлалаа бас. Би ч мэдэж л байгаа л даа бас ард түмэнд ийм мэдээлэл өгч байгаа нь зөв мэдээлэл өгч байгаа нь зүйтэй байх. Тэгээд нэг ийм байгаа юм. Ерөнхийдөө ингээд энэ өрсөлдөх чадвар чинь байхгүй болчихож байгаа юм аа. Би ямар утгаараа хэлэх гэж байна вэ гэвэл нэг компани, гаднын компани олборлоод өөрөө тээвэрлээд, өөрөө ашиглаад ингэнэ гэдэг ийм зүйл ер нь хаана ч улс оронд ямар ч газар байдаггүй байхгүй юу. Ийм юмыг хийчхэж байна. Нөгөө талаар ингээд 2 ордын тэр компани олборлоод ингээд хий хийж байх явцдаа нөгөө Хятад улсын аливаа улс орны өөрийнх нь нөгөө докторина ч гэдэг юм уу бодлого байдаг юм аа. Ерөөсөө тэр хүмүүсийнхээ ажиллаж байгаа орлого олж байгаа тэр яаж байгаа газар бол ямар нэгэн юугүйгээр хамгаалах гэж орж ирдэг. Ийм аюулгүй байдал талаасаа тэд нарыг хамгаална гэдэг ийм чиглэлтэй байдаг шүү. Энийг бид нар их сайн авч үзэх ёстой. Тэгэхгүй бол бид нар улс орноо зөв зүгээр байж байгаа юмыг тэгээд бөөн хэл аманд оруулахаар ийм маргаантай байдал руу шилжүүлэхээр ийм асуудал руу чирч гулгаж оруулж болохгүй шүү нөхдүүд ээ. Энийг заавал Аюулгүй байдлын байнгын хороон дээр хэлэх ёстой гэж бодож байгаа юм.

Би зүгээр олон улсын зарчмаараа далайд гарцгүй орны хувьд Монгол Улсыг Хятад улс бол аль ойрхон тээвэртэй усан боомттой газраа хүргэж өгөх өөрөө үүрэгтэй байдаг. Тэрнийхээ дагуу ч энэ том улс орнууд тэрийгээ биелүүлж байгаа гэж ойлгож байгаа. Гэтэл тэрнийг бид нар ашиглаж чадахгүйгээр шууд нэг компанид ганцхан компанид бүх юмаа аваачиж өгөөд тэд нарын гарт орчихвол энэ дараа нь алдаж болохгүй засаж болохгүй ийм зүйл болно. Тэр тусмаа өнөөдөр улс орон дэлхийн геополитикийн нөхцөл байдал ямар байгааг бүгдээрээ л ойлгож байгаа шүү дээ. Энэ дээр анхаармаар байна шүү нөхдүүд та бүхэнд би хэллээ шүү. Энийг одоо бас Монголын ард түмэн ч.

Г.Тэмүүлэн: Үг хэллээ. Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: Ер нь ингээд уул уурхайн томоохон төсөл хөтөлбөртэй холбоотой асуудал яагаад улс төржөөд популизмтай болоод удаж иргэдийн бухимдлыг гаргаад байдаг вэ гэхлээрээ олон нийтэд өгсөн хүлээлт ба бодит байдал 2 хоорондоо зөрөхөөр ийм зөрчил үүсгээд байдаг. Тэгэхээр энэ төсөл ч гэсэн эхнээсээ бас их мэдээллүүд нь тодорхой яваасай гэдэг ийм бодол байгаа. Тэгэхээр энэ эдийн засгийн симуляц хийгдсэн болов уу гэж бодож байна аа. Тухайлбал энэ төсөл хэрэгжсэнээрээ төмөр замаар экспортлох ачааны хэмжээг жилд 30 сая тонноос дээшээгээ Тавантолгойн ордны нүүрсний экспортын хэмжээг жилд 70 сая тонноос өсгөнө гэж байгаа. Тэгээд борлуулалтын орлогыг 1.5 тэрбум доллароор нэмэгдүүлэх жил бүрийн эдийн засгийн өсөлтийг 0.8 хувиар нэмэгдүүлэх улмаар ДНБ-ийг 10 мянган долларт хүргэнэ гэхихсэн байгаа юм.

Тэгэхээр ингээд одоо бид нар энэ гэрээг Их Хурлаар соёрхон баталлаа. Батлангуут энэ гүүрэн байгууламж жишээлбэл яг ямар хугацаанд баригдах юм бэ? Тэгээд энэ зорилт дээр байгаад байгаа эдийн засгийн үр өгөөжүүд ямар хугацаанд орж ирэх эдийн засгийн симуляц төсөөтэй аргын судалгаа хийгдсэн юм бэ? Энэ талаар их тодорхой мэдээлэл өгөөч.

Ганцмод-Гашуун сухайтаас гадна нөгөө Ханги Мандал, Шивээ хүрэн, Сэхээ, Бичигт, Зүүнхатавч гэдэг юм уу эд нар маань ингээд нийлээд эдийн засгийн тэлэлт ямар түвшинд хүрэхээр байгаа юм бэ гэдэг. Болж өгвөл хугацаатай өгөөч. Жишээлбэл энэ нь 2028 оноос өмнө энэ чинь явж байгаа шүү дээ. Тэгэхээр 25 онд

энэ гэрээ хэлцэл ингээд эцэслэгдлээ гэхэд яг бүтээн байгуулалтын ажил нь хэзээ гэхэд дуусаад эдийн засгийн эргэлтэд ямар хугацаанд энэ үр өгөөжүүд нь орж ирэх юм бэ гэдэг дээр маш тодорхой мэдээллүүдийг өгмөөр байгаад байгаа юм.

Хоёрдугаар асуулт нь болохоор түрүүн тэр Наранбаатар гишүүний хэлээд байгаа их чухал байгаа юм аа. Тэр яаж байна гэхээрээ манай талын тэр баригдсан байгууламжуудын доор бас ус шүүрээд нөгөө усыг нь шинжлээд үзэхлээрээ байгалийн бус химийн элемент бүхий ийм цагаан шохойтой юм шиг ийм ус нэвчиж гарч ирээд тэрийгээ бол нөхдүүд юу гээд байгаа вэ гэхлээр Хятадын хилээс доогуураа ингээд газрын гүний тэр нөгөө чулуулаг дээрээ ингэж нэвчиж орж ирээд байна гээд. Тэгээд энд бол яг энэ зөвхөн Эрдэс баялаг, аж үйлдвэрийн яамнаас гадна энэ стандартын асуудал байгаль орчлон экологийн асуудал учраас энэ дээр Засгийн газар маш сайн анхаарах ёстой юм байна лээ.

Энийгээ ч гэсэн хамтад нь шийдэх ямар боломжууд байна?

Дээрээс нь тэр Цогтцэций сумын хажуу талын баг нь хорин хэдэн мянган хүнтэй. Гэтэл тэнд яаж байна гэхээрээ нөгөө газар нь өөрөө тусгай хамгаалалттай газрын бүс нутаг учраас засаг захиргааны нэгж байгуулах боломжгүй. Тэнд цагдаагийн газар гэж байхгүй, гэрээт цагдаа нар ажиллаж байгаа шүү дээ. Тэр эргээд нөгөө нэг нийгмийн асуудал буюу хүний эрхийн зөрчлийн асуудал маш их болчихоод байгаа юм аа. Тэгэхээр энэ дээр зөвхөн нэг яамнаас илүүтэйгээр Засгийн газрын дундын салбар хоорондын уялдаа гаргасан маш том хөтөлбөр явуулахгүй бол болохгүй байгаад байгаа юм. Тэр бүсийн хилийн асуудал тэнд засаг захиргааны нэгжийг яаж тэгвэл тэндээ тогтвортой авч явах юм.

Мэдээж тэр чинь олон 10 км-ээс усаа татаж байгаа ч гэдэг юм уу энэ асуудлыг зүгээр хариулт нэхэхээс илүүтэйгээр энэ асуудал дээр.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Туваан сайд 5 номер.

Ц.Туваан: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя аа. Энэ эдийн засгийн ач холбогдлоосоо ярьж байна. Маш чухал асуудал. Энэ дээр бид нар бас Эдийн засаг хөгжлийн яамтай хамтарч энэ саяын таны ярьсан тооцооллуудыг гаргаж ирсэн. Ер нь бол яг бодит үр дүн бол энэ жил шууд эхний 5 сая тонныг борлуулж эхлэхээс эхлээд л гарч эхэлнэ. Яагаад гэхээр ойролцоогоор нэг 80 доллароор бодоход 5 сая тонн, энэ ондоо 400 сая долларын орлого нэмж орж ирнэ. Энэ бид нар бэлэн мөнгөөр борлуулах учраас. Тэгээд мэдээж 20 сая тонноор буюу 2030 оноос эхлээд борлуулахаар бол үүнээс 5 дахин, 4 дахин илүү эффе́кт гарч ирнэ гэдгийг бас хэлье.

Дээрээс нь энэ одоо хэлэлцээр, Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулагдсанаар 2 улсын хооронд шууд бус гэж хэлж болохуйц маш олон асуудлуудыг шийдэгдэнэ. Мэдээж бид нар ч гэсэн бас урд хөрштэй нэлээн олон удаа уулзаж ярилцахад бас өмнө нь гацаатай байсан асуудлууд дээр нэлээн уян хатан нааштай байдлаар асуудлууд яригдаж байгаа. Энэ Гашуунсухайтын төмөр замын хил холболтын ажил эхэлмэгц дараагийн асуудал буюу Шивээ хүрэн, Сэхээгийн асуудал шууд яригдаад эхэлнэ. Энэ бол Шивээ хүрэн-Сэхээ, Бичигт-Зүүнхатавч, Ханги, Мандал гэсэн дарааллаар бүүр цаашилбал баруун зүүн

коридороор төмөр замаар холбох энэ асуудлууд ингээд дамжаад дамжаад явна гэдгийг бас хэлье ээ.

Энэ утгаараа бас эдийн засгийн нэлээн өндөр эффектийг үзүүлнэ. Бид нарын хамтарсан Засгийн газрын барьж байгаа зорилго бол нэг хүнд ноогдох ДНБ-ийг 10 мянган ам.доллар-т хүргэх гэдэг энэ зорилтод энэ төслийн ажиллагаанууд бол нэлээн томоохон хувь нэмрийг оруулна гэдгийг хэлье ээ.

Хоёрдугаар асуудал дээр та тэр Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн асуудлыг ярьж байна. Энэ бол өөрөө одоо ТХГН-т ордог. Тэгэхээр тэрэн дээр орж байгаа гэдэг утгаараа энэ газрын асуудал бол маш хүндрэлтэй асуудал байдаг. Энэ дээр Хайрхан багийн төв байрладаг. Тэгээд бусад энэ газруудад нь ялангуяа жишээлбэл цагдаа эмнэлэг, дээрээс нь онцгой байдлын бүлэг байгуулах энэ тэр дээр гээд. Боомтыг өргөтгөх дээр энэ тэр гээд маш олон асуудал дээр газрын асуудал яригддаг. Тэгэхээр өнөөдөр хүртэл Засгийн газрын хуралдаан дээр энэ боомтын газрын асуудлыг шийдвэрлэх дээр хуульд өөрчлөлт оруулах нэг асуудлыг авч хэлэлцье гээд Боомтын асуудал хариуцсан сайд Тулга сайдад бас үүрэг өгсөн гэдгийг хэлье. Газрын геологийн байршлын хувьд бол энэ нэг тийм өндөршилтийн зөрүүтэй байршил байгаа. Өөрөөр хэлбэл Ганцмодын БНХАУ-ын Ганцмод талын боомт нь өндөр. Газрын дээд талд байгаа. Тэнд орсон борооны ус зэрэг уруйн ус энэ тэр бол наашаагаа Монголын тал руу урсаж орж ирж нэлээн хүндрэлүүдийг үүсгэдэг. Яг энэ утгаараа бас зарим мэдээллээр би бол яг мэргэжлийн хүн биш учраас тэр Хятадын талын нөгөө нэг хэрэглэсэн бохир саарал уснууд наашаа нэвчиж орж ирж магадгүй гэсэн зүйлийг ярьж байна лээ. Тэгэхдээ энийг бол яг мэргэжлийн хүмүүсээс нь тодорхой асууж байж танд хариулъя аа.

Г.Тэмүүлэн: Сая энэ гүүрэн байгууламжтай холбоотой бүтээн байгуулалтын ажлууд нь яг хэзээ эхлэх, хэзээ ашиглалтад орох, тэгээд түүнээс улбаатайгаар эдийн засгийн үр өгөөж гэдэг юм уу хугацаатай холбоотой асуудлууд асуусан.

Нэмж хариулъя. Туваан сайд 5 номер.

Ц.Туваан: Энэ танилцуулга дотор бид нар бас түрүүн хэлсэн. Энэ гүүрэн байгууламжийг нэлээн төвөгшилтэй байршилтай учраас нэлээн хугацаа шаардана. Хамгийн өндөртөө 30 метр буюу 10 давхар байшинтай тэнцэх хэмжээний өндөрт төмөр замын бетонон тулгуурууд дээр 2 төмөр зам зэрэгцэн явах тодорхой зайнууд байгаа гээд нэлээдгүй асуудлууд байгаа. Тэгэхээр энэ бүтээн байгуулалтыг хийхэд Зам, тэврийн яам бас нөгөө талтайгаа хэлэлцээд 270 сая ам.долларын төсөвтэй энэ байгууламжийг бол 50 сая ам.доллар-оор бууруулахаар барилга угсралтын ажил нь нийтдээ 30 сар буюу 2 жил хагас байсныг 22-оос 24 сар болгож бууруулах ийм шийдвэрт хүрч чадсан байгаа.

5 дугаар сарын 1 гэхэд тендер зарлагдаж дуусаад бүтээн байгуулалтын ажил эхэлнэ. 5 дугаар сарын эхний 10 хоногт энэ бүтээн байгуулалтын нээлтийн үйл ажиллагаа болно.

Г.Тэмүүлэн: Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Сайн байцгаана уу энэхүү хэлэлцээрийн асуудал бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо болон Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэд хэдэн удаа хэлэлцэж байгаа. Бас тогтоол гарсан байгаа. Хамгийн

сүүлд бол энэ асуудлыг Байнгын хороогоор хэлэлцэхэд бол Байнгын хорооны гишүүд бас тодорхой хэдэн саналуудыг ажлын хэсэгт хэлсэн байж байгаа. Тэдгээр саналуудын бас зарим нэг нь бас томьёоллын хувьд арай сайжирч орж ирсэнд ажлын хэсгийн ахлагч Туваанд талархаж байна. Нөгөө талаас сая протоколд дурдагдлаа. Протокол бас сая Харбинд зурагдсан юм байна. Тэгээд протоколыг бас протоколтой танилцах хүсэлтэй байгаагаа бас хэлье. Араас нь болохоор 3 гэрээ байгуулагдана гэж ойлгоод байгаа. Тэгэхээр яах вэ зүгээр процессын хувьд бас нэг асуудлыг нарийвчилж ойлгох хүсэлтэй байгаад байна л даа. Тэгэхээр энэ 3 гэрээ хэзээ байгуулагдах вэ тэ? Сая бас зарим зүйлийг нь дурдах шиг боллоо. Тэгээд эдгээр 3 гэрээтэй холбоотой тендерүүд явна гэж ойлгоод байгаа. Тэгэхээр энэ тендерүүд ямар түвшинд ямар түвшинд яаж зарлагдах юм? Эхний бүтээн байгуулалтын тендер 5 сарын 1 гээд сая хэлчих шиг боллоо. Тийм тэгэхээр энэ нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх тендер яаж хэрхэн яаж зарлагдах юм. Тэгээд хэзээ яаж дүгнэгдэх юм гэдэг тал дээр бас яг энэ процесстой холбоотой тодорхой мэдээллүүдийг бас өгнө үү? Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Жаргалан гишүүний асуултад хариулъя. 5 номер.

Ц.Туваан: Жаргалан гишүүний өмнөх Байнгын хороон дээр хэлсэн саналууд маш зөв зүйтэй саналууд тусгагдсан гэдгийг бас хэлье. Энэ дээр нөгөө 2 талын хамтын ажиллагаанд Хятадын ААН-үүдийг давуутай байж болохуйцаар тийм үг өгүүлбэр орсон байсныг арилжааны зарчмаар хамтран ажиллана гэсэн ийм байдлаар оруулж өгсөн.

Дээрээс нь протоколыг бас бид нар хэвлэж танд өгье. Энэ шууд энэ гэрээ соёрхон батлагдмагц шууд энэ ажлууддаа орно. Энэ 3 гэрээний ерөнхийдөө төмөр замын нүүрс худалдах, худалдан авах, уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх энэ гэрээнүүд нь драфт нь бэлэн болчихсон байгаа. Одоо яг энэ шийдвэрээ хүлээгээд л байж байгаа гэж ойлгож болно. Тэгээд энэ дээр эхнийх нь энэ төмөр замын гэрээ бол шууд 2 улсын тендерээ зарлаад л тэгээд 5 сарын 1-ний дотор шалгараад л тэгээд л бүтээн байгуулалтынхаа ажил руу шууд орох асуудал орно. Нүүрс худалдах, худалдан авах гэрээ бол Эрдэнэс Тавантолгой компани, Чайна Энержи компанийн хооронд шууд гэрээгээ хийгээд энэ худалдах, худалдан авах асуудал учраас шууд энэ худалдаандаа орно гэж ойлгож болно.

Гурав дахь асуудал дээр нь бол 2 уурхайн хүчин чадал өргөжүүлэх хүрээнд хамтын ажиллагааны ерөнхий гэрээг эхэлж байгуулна. Үүний дараа оператор компанийнхаа тендерийг зарлаад явна гэдгийг танд хэлье.

Г.Тэмүүлэн: Болсон уу Жаргалан гишүүн. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу нэрсийг авъя. Ганбат гишүүнээр тасаллаа. Хосбаяр гишүүн үг хэлнэ ээ.

Г.Хосбаяр: Тэгэхээр энэ төслийн маань зураг төсөл зураг төсөв нь мэдээж олон улсын норм стандарт бас жишгийг хангаж байгаа л гэж ойлгож байгаа. Тийм учраас энэн дээрээ бас сайн хяналт тавиарай. Дээр нь одоо бид нар ер нь энэ томоохон бүтээн байгуулалт, төслийн ажлуудын график, үе шатны ажил дээр бас онцгой анхаармаар байгаа юм аа. Одоо 2.5 жилийн дараа дуусна гэж байна.

Монголын талын өргөн байгууламж, Хятадын талаас орж ирэх нарийн байгууламж 2 том байгууламж хийнэ ээ. Тэгэхээр Монгол тал Тавантолгой маань Эрдэнэс Тавантолгой маань хөрөнгөө гаргаж байгаа юм чинь Монгол талынхаа өргөн терминалыг заавал 2 жил хагас хүлээхгүйгээр урд нь ашиглалтад оруулж байх эсвэл Хятад талын орж ирж байгаа нарийныг ашиглалтад оруулах боломж ажлаа хурдан гүйцэтгэх тэр тал дээр нь бас сайн судлаарай. Тэгэхгүй бол бид нар чинь жишээ нь Дорноговийн Алтанширээгийн нефтийн үйлдвэр дээр гэхэд нефть нэрэх үйлдвэрээ бариагүй байж байж цаанаас түүхий нефтээ татах хоолойгоо түрүүлээд бариад байгаа хүмүүс шүү дээ. Тэгэхээр энэ ажлын график аль түрүүлж хийж болох ажил аль нь ер нь ашигтай байна гэдэг юмаа сайн тооцож явмаар байгаа юм аа.

Тэгэхээр миний хувийн бодол тэр нарийн орж ирж байгаа нарийн байгууламж юм уу Монголын талаас хийх тэр өргөн байгууламж хоёрынхоо аль нэгийг нь жилийн дотор ч юм уу ашиглалтад оруулж байвал бас бидэнд л хэрэгтэй ийм зүйл байгаа. Тэгэхээр энэ ажлын үе шатын график энэ дээрээ онцгой анхаараарай. Тэгэхгүй бол заавал 2 жил хагасыг хүлээгээд нэг юмнуудаа эрэмбэлэх тал дээр бас анхаарна уу гэж ийм үг хэлэх юм аа. Баярлалаа та бүхэнд.

Г.Тэмүүлэн: Наранбаатар гишүүн.

Н.Наранбаатар: Төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тэр орон нутгийн асуудал хүмүүсийн Үндсэн хуулиар эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахтай холбоотой асуудал, хот тосгон, суурьшлын бүсийн асуудал гээд олон асуудлуудыг хамтад нь цогцоор нь бас та бүхэн анхааралдаа авч шийдвэрлэж явах зайлшгүй шаардлагатай. Тухайлах юм бол ганцхан баялаг гардаг биш бас зөрөөд бараа бүтээгдэхүүн, гуравдагч орны хүн, иргэн, бараа бүтээгдэхүүн ордог Замын-Үүд, Эрээн шиг ийм зэрэглэлийн боомт болгож тохижуулах ийм 2 орны ард иргэдэд аль алинд нь хэрэгтэй тустай ийм боомт байх шаардлагатай. Боомт дээр ажиллаж амьдарч байгаа төрийн албан хаагчдын ажиллаж амьдрах, амрах орчин нөхцөл, тэр тоног төхөөрөмж лаборатори гээд олон зүйлүүд тэнд маш их дутагдалтай байгаа. Мөн үүнийгээ дагаад төвлөрөл бий болно. Энэ Цагаан хадны суурьшлын бүс, Хайрхан багийн асуудал маш олон хүмүүс амьдарна. Өнөөдөр ямар ч эмх замбараа байхгүй. Тэгээд хүй нэгдлийн хуулиараа тэнд л өөр өөрийнхөө дур зоргоор л амьдарч байна. Ямар ч зохион байгуулалт байхгүй байна аа. Саяхан би бас Өмнөд Судан улсад очсон. Дотоодын мөргөлдөөнтэй зөрчилдөөнтэй ийм улсад очиж ажилласан. Тэр талаараа бас өөрийнхөө нүүр хуудсан дээр мэдээлэл тавьсан. Тэгээд хүмүүс надаас асууж байсан. Та Цагаан хадан дээр явж байгаа юм уу гээд асууж байсан.

Тэгэхээр ийм л байдалтай хүнд нөхцөлд хүмүүс тэнд шороон шуурганд ийм байдалтай л ажиллаж амьдарч байгаа. Мөн замын асуудал төмөр зам ашиглалтад орсон ч гэсэн авто зам бас хажуугаар нь явж байгаа. Замын нөхцөл байдал хүнд, аваар осол гардаг, мал амьтан дайруулдаг барьдаг, хүн амьтны амь нас сүүлдэг. Маш олон асуудал энэ авто тээвэртэй холбоотой гарч байгаа. Мөн энэ нүүрс ачиж буулгах талбайнууд дандаа гаднын хүмүүсийн эрх мэдлийн болчихсон. Үндэсний ААН компаниуд нь байхгүй болоод шахагдаад гараад явчихсан. Тээвэр нь ч гэсэн бас манай үндэсний компаниуд байхгүй болоод ингээд ажилгүй зогсчихсон олон хүн ажил амьдралгүй өр зээлдээ баригдчихсан. Тэгээд наашлах юм бол тэр сумын асуудлууд их хүндрэлтэй. Цогтцэций сум хамгийн л эмх замбараагүй хөгжил байхгүй ийм сургууль цэцэрлэг, нийгмийн үйлчилгээ, төрийн үйлчилгээ хүрэх ийм боломж байхгүй болчихсон. Хүн нь хэтэрчихсэн төсөв юмнууд нь төрийн байгууллагуудынх

нь үйл ажиллагаа нь доголчихсон ийм хүнд байдалтай. Малчдын асуудалд худаг усны асуудал, бэлчээрийн асуудал гээд маш олон асуудлууд тэр бүс нутагт өнгөрсөн хугацаанд хуримтлагдаад бий болсон ямар ч арга хэмжээ авсан юм байхгүй. Зөвхөн ухаж аваад явах ийм сэтгэлгээгээр хандсанаас орон нутгийн асуудал их хүндрэлтэй болчихсон шүү.

Дараа дараагийн бидний том төслүүд явахад Цогтцэций сум, Ханбогд сум, Цагаан хад Хайрхан баг бол жишээ болно шүү. Ард иргэд бас үүнийг сохор биш харж л байгаа. Олон газраас 21 аймгаас хүмүүс очиж тэнд ажиллаж байгаа, орлого олж байгаа, ар гэрээ тэжээж байгаа тэгээд байгаа сумынх нь байдал тэнд байгаа хүмүүсийн амьдрал ямархуу байна вэ гэдгийг харж байгаа учраас бид нар энэ дээр нь онцгой анхаарч цаашдаа явах нь зүйтэй. Орон нутагт нь үр өгөөжтэй л байх ёстой шүү. Өнөөдрийн хуулиар бол бүх татварыг нь улсын төсөв рүү татаад авчхаж байгаа юм. АМНАТ татаад авчхаж байгаа юм. Эргээд нэг шүлс хаяж байгаа юм шиг жоохон юм хуваарилдаг. Хаанаа ч хүрдэггүй ийм байдалтай байгаа. Цаашдаа тэгээд ер нь төсөл хэрэгжиж байхад орон нутагт нь АМНАТ болон бусад татвар хураамжуудаас нь тодорхой хэмжээгээр энэ Канад шиг, Австрали шиг ингээд үлдээгээд өгөх юм бол орон нутаг чинь аяндаа бас энэ төслүүдийг дэмжээд ингээд явах болно шүү л гэдгийг хэлье.

Тэгээд цаашаа байгуулагдах 3 гэрээндээ энэ асуудлуудыг тодорхой тусгаж тэр уурхайн үр өгөөжөөс орон нутаг руу нь чиглүүлж өгөөрэй л гэсэн.

Г.Тэмүүлэн: Баярлалаа Наранбаатар гишүүнд. Болормаа гишүүн үг хэлнэ.

Э.Болормаа: Ингээд цаг алдалгүй энэ асуудлыг бас оруулж ирж байгаа ажлын хэсгийнхэндээ талархал илэрхийлье. Дэмжиж байна. Тэгээд бид нарын хувьд dkl энэ стратегийн асуудал дээр гуравдагч талын оролцоогүйгээр 2 орны Засгийн газар ийм хэлэлцээр хийнэ гэдэг бол маш том түүхэн амжилт. Үүнийг дагуулаад маш том хариуцлага яг хэрэгжүүлэгч байгууллага буюу эрд бизнес Тавантолгой дээр ирж байна гэж би харж байгаа юм. ТӨК хэрвээ энэ хэрэгжилт дээр алдах юм бол цаашид байгалийн баялгийн асуудал, энэ стратегийн асуудал үндэсний баялгийн сангийн хэрэгжилтийн асуудал, иргэдийн биднээс шаардаж байгаа энэ байгалийн баялагтаа бүгд эзэн болох асуудал тэр чигээрээ унах ийм магадлалтай.

Тэгэхээр энэ хэрэгжилт өнөөдөр бид соёрхон батлаад Их Хурлаар ороод 3 гэрээ хийгдээд яг хэрэгжилт дээрээ очиж алдав гэдэг зүйлийг би өмнө нь ч хэлж байсан. Одоо дахин дахин давтмаар байгаа. Яагаад гэвэл энэ зөвхөн ЭТТ-н асуудал биш, энэ зөвхөн ганц төмөр замын холболтын асуудал биш. Энэ цаашдын тэр чигээрээ Монгол Улсын хөгжлийн замнал тэр дундаа стратегийн асуудал дээр төр өөрөө ингэж оролцох нь зөв үү буруу юу гэдэг энэ асуудал руу явна аа.

Тэгэхээр та бүхний нуруун дээр маш том хариуцлага ирж байгаа гэж харж байна. Тэр ч утгаараа хэрэгжүүлэх хүмүүс анхнаасаа бүх шат дараалалтай иргэдийн оролцоотой би энэ Наранбаатар гишүүний хэлж байгааг бүр дахин дахин давтаж хэлмээр байна. Зөвхөн Өмнөговь гэж хэн ч харахгүй. Өөр ямар ч аймгийн хүн дараа нь, өөрийнх нь аймаг орон нутагт нь, суманд нь ямар нэгэн зүйл хэлэхэд хар даа тэр Өмнөговьд энэ болоогүй шүү дээ. Энэ асуудалтай байсан шүү дээ гэдэг асуудлаар эдгээр зүйлсийг эсэргүүцэх болно.

Тийм учир орон нутгийн иргэддээ хэлэлцүүлэг явуулахаас авхуулаад яаж үр өгөөжийг нь орон нутагт нь нэмэгдүүлэхээс авхуулаад энэ асуудал дээр илүү санаачилгатай ажиллах зүгээр энэ АМНАТ-ийн төлбөр байхгүй биш. Наад зах нь хэдэн багуудаар сумууд дээр энэ төмөр замын холболтынхоо энэ гэрээгээ хэлэлцүүлнэ гэдэг хүртэл орон нутгийн иргэдийн оролцоо шүү. Сая одоо жишээлбэл мөн Жаргалан гишүүн энэ дараа бөөн тендер худалдан авалт явахад яаж орон нутгийн ААН-үүдээсээ хоол хүнс махнаас нь авхуулаад худалдан авалт явуулах вэ? Энэний үр өгөөж яаж Өмнөговь нутгийн иргэдэд хамгийн түрүүнд хүртээмжтэй байх вэ. Дараа нь Монгол Улсын хэмжээнд гэдэг байдлаар хараарай.

Яагаад гэвэл бүх танилцуулга дээр бид нар нийтдээ улсын хэмжээний эдийн засаг ярьж байгаа. Энэ үнэн. Стратегийн асуудал. Гэхдээ ийм юм хэрвээ орон нутагтаа дэмжлэг авахгүй бол хэзээ ч цаашаа дэмжлэг авдаггүй шүү. Тийм болохоор хэрэгжилт дээр энэ том онцгой хариуцлагыг бас та бүхэн ухаарч орон нутгийнхаа иргэдийг оролцуулах мөн цаашдаа Монгол Улс энэ Үндэсний баялгийн сангаа хэрэгжүүлэхэд байгалийн баялгаа ингэж гуравдагч талын оролцоогүйгээр авч явах нь зүйтэй юм гэдэг энэ зүйлийг баталгаажуулах ийм том хариуцлага байгаа юм шүү гэдгийг хэлье. Тэгээд та бүхэндээ дахиад амжилт хүсье ээ. Цаг алдалгүй бас ажиллаж энэ 14 мега төслийн нэн тэргүүнийг ингэж бас хурдацтай анхаарч ажиллаж байгаад ажлын хэсгийн хамт олон бас талархал илэрхийлье.

Г.Тэмүүлэн: Жангабыл гишүүн үг хэлье.

Х.Жангабыл: Баярлалаа. Нүүрсний чанар маш чухал асуудал л даа. Энэ нүүрсний чанар зэргийг анхаарах хэрэгтэй. Цорчилж зарах, зарж болохгүй гэсэн хуультай. Тэгэхээр энэ уурхайгаас гарч байгаа бүх нүүрсийг бол нөгөө талдаа бол борлуулах нэг ч юм үлдээлгүйгээр өгөх л хэрэгтэй. Түрүүн Туваан сайд дурдана билээ. 55, 35, 10 гэсэн харьцаагаар бид нар тохирсон гээд. Тэгэхээр шинээр нээх гэж байгаа уурхайгаас ийм харьцаагаар гарахыг нь та яаж мэдэж байгаа юм бэ? Тэгэхээр ер нь тэр шинээр нээх гэж байгаа уурхайгаас гарсан нүүрсийг нь бүгдийг л нөгөө талдаа борлуулах л гэрээн дээр тусгах хэрэгтэй Эрдэнэс Тавантолгой бол гэрээг хийх юм байна. Монголын талаас би тэгж ойлгож байна. Тэгэхээр энэ тал дээр их анхаарах хэрэгтэй. Ер нь гэрээн дээр бол хугацаа үнэ чанар шүү дээ. Энэ тал дээр их анхааралтай Монгол Улсаа бодсон тийм гэрээ л хийгээрэй гэж хүсэж байна даа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн үг хэлье.

Д.Ганбат: Ингээд зах зухаас л зүгээр нэг боломж олдох юм бол асуухад л тэр хил дамнасан, хил холболт гэдгээ ингээд л нэг зөрөө нь гарч ирж байна. Тэр 2 ордыг Тавантолгойн 2 орд гэдэг чинь Тавантолгойтой 40 хувь нь л гэсэн үг байхгүй юу. 40 хувийг нь өгчхөөд нэгдүгээрт. Өгөх нь ч яах вэ тэгээд өгчихдөг л юм байгаа биз. Тэрний тэгээд улс орны аюулгүй байдалд нөлөөлөх тэр дүгнэлт энэ тэр юм хум нь гарсан юм уу үгүй юм уу. Энэ дээр анхаарах хэрэгтэй. Нөгөө талаар бол зүгээр 10 мянган долларт хүргэнэ л гэж яриад байгаа юм. Уг нь бол зүгээр ажиллуулаад л ингээд л жам ёсоор нь явсан бол аль 10 жилийн өмнө л хүрчихээр л ийм юм л даа.

Өнөөдөр 3 сая 500 мянган хүн бүгдээрээ л саятнууд, долларын саятнууд болчихсон ингээд сууж байх бүрэн боломжтой. Яагаад гэвэл Эрдэнэс Тавантолгойн бүгдээрээ л хувьцаа эзэмшигчид байгаа шүү дээ. Тэгэхэд яаж ажиллаж байгаа билээ. Тэнд ажиллаж байсан хүмүүсийг нэлээн хэд нь өнөөдөр шоронд сууж байна.

Тэр Ерөнхий захирал байсан нөхөр сууж л байна. Улсын Их Хурлын дэд дарга байсан нөхөр ч гэсэн сууж л байна. Энэ юмтай холбоотой юм уу, холбоогүй юм уу гэдгийг нь тэр шүүхийн шийдвэр энээ тэрээ юм мэдэхгүй юм байна. Гэтэл хувийн хэвшил одоо нэг дөрөвхөн хувийг нь эзэмшээд ажиллахад яаж ажиллаж чадаж байна вэ. Бас ичмээр л байгаа байхгүй юу. Энэ юман дээр нөхдүүд анхаараарай. Тэгээд зүгээр нөгөө мухар төмөр зам чинь зүгээр хил давж л байгаагаас биш тэрнээс биш холбогдоод байгаа юм ерөөсөө алга. Бид нар үнэхээр тэр нүүрсээ гуравдагч орны зах зээлд нийлүүлээд дэлхийн зах зээл дээр гаргаж чадахгүй. Ганцхан төрийн өмчтэй Хятадын компанийн хараат ийм болох юм руу та нар аваачаад хийчихсэн ийм байх вий. Ер нь тэр тийшээ л яваад байх шиг байна. Одоо ингээд засаж залруулах боломжтой ийм үедээ энийгээ засаж залруулбал зүгээр байна аа.

Хэрвээ засаж залруулж чадвал бид нар бол Монголын иргэд 3 сая 500 мянган хүн 3 сая 500 мянгуулаа саятнууд болж чадахаар байна. Одоо нүүрсний үнэ ойрын нэг 2, 3 жилдээ л гайгүй байх байх 5 жил, 10 жилийн дараа бол тийм байж чадахгүй гэсэн ийм анализ энэ тэрийг хийж өгч байна шүү дээ. Энэ дээр бид нар мэдэж байгаа юмаа мэдэхгүй юм шиг царайлах хэрэггүй байна. Олон гадаад дотоодод сургууль төгсөж ирсэн 126 Их Хурлын гишүүнтэй болчихсон гээд байгаа шүү дээ бид нар чинь. Харвард энэ тэр төгссөн зөндөө хүмүүс байж байгаа гэж байгаа. Гэтэл энэ юмаа олж хардаг юм уу хардаггүй юм уу. Ерөөсөө энэ Улсын Их Хурал дээр нэг их үнэн үг сонсогдохгүй л байна шүү дээ ерөөсөө. Яг байгаа байдлыг нь бодитоор би зүгээр л ингээд харж байхад л тийм байна шүү дээ. Олон хүн цалин аваад та нар дотор ажиллаж байна. Хэн нэгэн хувь хүнээс авч байгаа юм ерөөсөө байхгүй. Та нар Монголын ард түмэн татвар төлөгчдийн мөнгөөр л цалинжиж байгаа. Тэгтэл яг тэрний төлөө ажиллаж чадаж байна уу үгүй юу?

Хэрвээ Ардчилсан нам сөрөг хүчин байгаад ингээд хийсэн бол ийм өрөөл татанхай гэрээ хийлгүүлэхгүй байсан байх. МАН бол дуусчхаад байна шүү дээ. Одоо ингээд ийм өрөөл татанхай гэрээ засагт оруулж хийчхээд эцэст нь Монголын ард түмэн хохироод зүгээр нэг үртэс шиг юмаар нэг аргацаагаад ийм л юм өнгөрөх гээд байна шүү. Ийм сайхан боломжтой энэ ордыг 20 жил, 30 жил ашиглаж чадаагүй. Олон хүн хулгайлаад баяжсаар байгаад л дууссан. Тэгээд тэд нарын хөрөнгө мөнгийг нь нөгөө хурааж барих шүүхийн зүйл заалт энээ тэрээ юм байдаг. Би лав хураасан гэж дуулаагүй. Тэгээд л нэг попорсон хэдэн улсууд Монголын ард түмэн цаана чинь хохироод л байж байна. 30 хувь нь ядуу байсан одоо хэвээрээ л байна. Гэх мэтчилний ийм зүйлүүд байгаа шүү. Тэгээд хэн нэгэн хүн үг хэлэхээр асуухаар тэрийг нь янз бүрээр гаргаж ирдэг. Зохион байгуулалттай сэвдэг. Хаанаас ч санхүүжилт авдаг юм тэр мэрийг нь мэдэхгүй байна. Тэр мэрийг нь шалгаж тогтоох хэрэгтэй.

Г.Тэмүүлэн: Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалтыг явуулна. Гишүүдийг дуудаарай.

Засгийн газрын ажлын хэсгийнхэн бас анхаарч ажиллаарай. Гишүүдийн бас хэлж байгаа саналууд дээр бас бид нар хэд хэдэн удаагийн асуудлууд бас орсон тогтоол орсон. Өмнө нь энэ хэлэлцээрийг хэлэлцэх эсэх асуудал орсон. Өнөөдөр соёрхон батлах асуудлыг манай Байнгын хороо оруулж ирж байна. Өмнө 2 Байнгын хорооноос хамтарч хамтарч хуралдаж 30 гаруй гишүүд бас санал байр сууриа хэлж байсан байгаа. Тэгэхээр бол бид нар үндсэндээ яг та бүхэн бас нарийвчилсан цаад тэр компани хоорондынхоо 3 гэрээн дээрээ байна уу ажлын хэсгийнхээ протоколууд

дээрээ байна уу яг ямар байдлаар тусгагдаж байгааг бол нарийвчилж мэдэхгүй байгаад байгаа. Ямар ч бай гишүүдийн хэлсэн саналуудыг та бүхэн ажил хэрэг болгож бол тусгах ёстой байгаад байгаа шүү. Засаж залруулах нийцүүлэх гэдэг асуудлууд дээр хэд хэдэн саналуудыг гишүүд хэлж байсан. Хариуцлагатай ажиллаарай.

Энэ бол 2 улсын Засгийн газрын хоорондын хэлэлцээр учраас харилцан ашигтай байх дээрээс нэг талдаа Монголын талын эрх ашгийг бас хангуулах асуудлыг гишүүд онцолж хэлээд байгаа. Тэгэхээр сая бас сүүлд гишүүд хэлж байна. Энэ авто зам авто зам болоод тээвэр боомтын орчин нөхцөлтэй холбоотой орон нутгийн хөгжил үндэсний ААН-үүдийн оролцоотой холбоотой ч гэдэг юм уу. Эдгээр асуудлууд дээр бол бас онцгойлж анхаарч бол бас ажиллаарай л гэдэг зүйлийг хэлье.

Нэр бүхий бас гишүүдийн нэг ажлын хэсэг хооронд байгуулах протоколтой танилцах хүсэлтийг өгсөн. Та бүхэн гишүүдэд бас протоколыг танилцуулаад ингээд яваарай л гэсэн саналыг бол хэлэх байна.

Ингээд санал хураалтыг явуулж эхэлье. Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтыг явуулж эхлэхээр байна. Гишүүд ирж байна уу?

Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай байж саналаа өгөөрэй.

Санал хураалт батлахыг дэмжье гэдгээр санал хураалтыг явуулъя.

Санал хураалтад 20 гишүүн оролцсоноос 18 гишүүн дэмжлээ.

Протокол дээр Жаргалан болон Ганбат гишүүд дэмжсэнээр орж байна. Санал хураалт дэмжигдлээ. Ингээд санал хураалтыг явуулж дууслаа.

Ингээд 2 улсын Засгийн газрын хоорондын хэлэлцээрийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд бас илтгэх байгаа. Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар гишүүн нэгдсэн хуралдаан илтгэнэ ээ. Ингээд төслийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Идэвхтэй оролцсон ажлын хэсэг болоод Байнгын хорооны гишүүддээ баярлалаа.

14.40 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА